



ШУДАРГА ЁС,
ХӨГЖИЛ
ДЭВШИЛД



БОДЛОГЫН ШИЙДЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТАЛААР БОДЛОГОД ОРОЛЦОГЧ, ШИНЖЭЭЧДИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот, 2025 он

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТАЛААР БОДЛОГОД ОРОЛЦОГЧ, ШИНЖЭЭЧДИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Захиалагч: Авлигатай тэмцэх газар
Гүйцэтгэгч: “Бодлогын шийдэл” ТББ

Улаанбаатар хот, 2025 он

Энэхүү тайлан нь “Шударга байдлын үнэлгээ – 2025” судалгааны “Төрийн байгууллагын шударга байдлын талаар Бодлогод оролцогч, шинжээчдийн судалгаа”-ны тайлан юм. Судалгааны мэдээллийг ашиглахтай холбоотой бүх эрхийг “Авлигатай тэмцэх газар” эзэмшинэ. Тайланд дурдагдаж буй үр дүнг АТГ-аас хараат бус байдлаар гүйцэтгэсэн бөгөөд “Бодлогын шийдэл” ТББ-аас явуулсан судалгаанд оролцогчдын үнэлгээний үр дүнд үндэслэгдсэн болно.

СУДАЛГААНЫ БАГ:

Судалгааны багийн ахлагч: Доктор Ж.Баттулга

Тайлан боловсруулсан: Доктор, профессор Н.Нямаа

Мэдээлэл цуглуулалтын баг:

Ж.Баттулга
Г.Оюун-Эрдэнэ
Ж.Сувдаа
А.Энхтуяа
О.Балжин
З.Сайнжаргал
Л.Баярцэцэг
Б.Гантөмөр
И.Батхишиг
Б.Нарантуяа
Л.Мишээл
Г.Бадамцэцэг
Д.Итгэлмаа
Баяртуяа
Н.Номундарь
Н.Эрдэнэцэцэг
Б.Итгэлмаа
Т.Нямсайхан
Ж.Саруултуяа
О.Сарангоо
А.Амаржаргал
Ү.Ану
Б.Цэцэг

АГУУЛГА

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	5
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	6
НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР	7
ТАЛАРХАЛ	8
ХУРААНГУЙ	9
БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	12
1.1.Шударга байдлын үнэлгээний аргачлал	12
1.1.1. Судалгааны зорилго, зорилт	12
1.1.2. Үнэлгээний загвар	12
1.2. Судалгааны хамрах хүрээ	13
1.3 Судалгааны мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалт	14
БҮЛЭГ 2. БОДЛОГОД ОРОЛЦОГЧ, ШИНЖЭЭЧДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН.....	15
2.1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл.....	15
2.2 Бодлогод оролцогч, шинжээчдийн үнэлгээний ерөнхий үр дүн.....	15
2.2.1 БОУ хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд	17
2.2.2 Яамдын бодлогод оролцогчдын үнэлгээ	19
2.2.3 Агентлагуудын бодлогод оролцогчдын үнэлгээ	21
2.2.4 Аймаг, нийслэлийн бодлогод оролцогчдын үнэлгээ.....	23
2.2.5 Дүүргүүдийн бодлогод оролцогчдын үнэлгээний үр дүн	25
2.3 Бодлогод оролцогчдын үнэлгээний дэд үзүүлэлтийн үр дүн	26
2.4. БОУ гүйцэтгэл багатай байгууллагууд	31
2.4.1. Хамгийн бага үнэлгээтэй байгууллагууд.....	31
БҮЛЭГ 3: МОНГОЛ УЛС ДАХЬ АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ.....	39
3.1 Монгол Улс дахь авлигын өнөөгийн нөхцөл байдал.....	39
3.2 Монгол Улс дахь авлига хамгийн их тархсан институц.....	39
3.3. Монгол Улс дахь авлигын үндсэн шалтгаан, нөхцөл	41
3.4. Монгол Улс дахь авлигын ирээдүйн 2 жилийн төсөөлөл	42
3.5 Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үнэлгээ	43
ДҮГНЭЛТ	44
Ашигласан материалын жагсаалт	47
ХАВСРАЛТ	48

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 1-5 хүртэл хэмжээс бүхий хариултыг ШБҮ-ний 0-100 оноонд шилжүүлэх	13
Хүснэгт 2. Судалгаанд оролцсон бодлогод оролцогч, шинжээчийн төлөөлж буй хүрээ	15
Хүснэгт 3. БОҮ, хамгийн өндөр болон хамгийн бага оноо авсан байгууллагууд	17
Хүснэгт 4. БОҮ, хамгийн өндөр оноо авсан 5 байгууллагын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ	18
Хүснэгт 5. БОҮ, хамгийн бага оноо авсан 5 байгууллагын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ	19
Хүснэгт 6. Яамдын БОҮ, 2024, 2025 оныг харьцуулсан байдлаар	19
Хүснэгт 7. Агентлагуудын БОҮ, 2024, 2025 оныг харьцуулсан байдлаар	21
Хүснэгт 8. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОҮ, 2024, 2025 оныг харьцуулсан байдлаар	23
Хүснэгт 9. Дүүргүүдийн БОҮ, 2024, 2025 оныг харьцуулсан байдлаар	25
Хүснэгт 10. Яамдын БОҮ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2024 онтой харьцуулсан байдал	27
Хүснэгт 11. Агентлагуудын БОҮ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2024 онтой харьцуулсан байдал	28
Хүснэгт 12. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОҮ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2024 онтой харьцуулсан байдал	29
Хүснэгт 13. Дүүргүүдийн БОҮ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2024 онтой харьцуулсан байдал	30
Хүснэгт 14. БОҮ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, байгууллагын төрлөөр, 2024 онтой харьцуулсан байдал (нэгтгэсэн)	31
Хүснэгт 15. Шүүх шинжилгээний ерөнхий газрын БОҮ-ний дэд үзүүлэлт, түүний өөрчлөлт	32
Хүснэгт 16. Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ -ын БОҮ, түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт	33
Хүснэгт 17. Архангай аймгийн ЗДТГ-ын БОҮ, түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт	34
Хүснэгт 18. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны БОҮ, түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт	36
Хүснэгт 19. Боловсрол шинжлэх ухааны яамны БОҮ, түүний дэд үзүүлэлтүүд	37
Хүснэгт 20. Монгол улсад авлига хамгийн их тархсан институт, хариултад эзлэх хувиар	39
Зураг 1. Үнэлгээний загвар	12
Зураг 2. Түүврийн хамрах хүрээ, түүврийн хэмжээ	14
Зураг 3. Мэдээлэл цуглуулах багийн зохион байгуулалт	14
Зураг 4. БОҮ, оноогоор, байгууллагын төрлөөр	16
Зураг 5. БОҮ, дэд үзүүлэлтээр, оноор	26
Зураг 6. БОҮ-ний дэд үзүүлэлт, байгууллагын төрлөөр, 2025 он	27
Зураг 7. Монгол улс дах авлигын өнөөгийн нөхцөл байдал, хувиар	39
Зураг 8. Бодлогод оролцогч, шинжээчдийн хувьд авлигыг бууруулах, албан хаагчдыг авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд хийх шаардлагатай зүйлс, хариултад эзлэх хувиар	40
Зураг 9. Монгол улс дах авлигын үндсэн шалтгаан, нөхцөл, хариултад эзлэх хувиар	41
Зураг 10. Ирэх 2 жилд Монгол улс дах авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх төсөөлөл	42
Зураг 11. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үнэлгээ, хувиар	43

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АТГ- Авлигатай тэмцэх газар

БОҮ- Бодлогод оролцогч, шинжээчдийн үнэлгээ

ЗДТГ- Засаг даргын тамгын газар

ЭБАТ- Эрх бүхий албан тушаалтан

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

“Авлига” гэж Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг” заасныг хэлнэ.

“Шударга байдлын үнэлгээ” гэж тухайн байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ, дотоод шударга байдлын үнэлгээ, бодлогод оролцогчдын үнэлгээ, авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээнд үндэслэсэн нийт үнэлгээг;

“Шударга байдлын үнэлгээний судалгаа” гэж гадаад шударга байдлын үнэлгээ, дотоод шударга байдлын үнэлгээ, бодлогод оролцогчдын үнэлгээг хийхээр зохион байгуулж буй судалгааны нийлбэр цогцыг;

“Бодлогод оролцогчдын үнэлгээ” гэж тухайн байгууллагын шударга байдлын талаарх бодлого боловсруулах, төлөвлөх үе шатанд оролцогчдын өгсөн үнэлгээг;

“Төрийн үйлчилгээ” гэж төрийн байгууллага, төрийн албан хаагчаас хууль тогтоомжид заасан чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд иргэд, бусад байгууллагад үзүүлж буй аливаа үйлчилгээг тус ойлгох юм.

ТАЛАРХАЛ

“Төрийн байгууллагуудын шударга байдлын талаар бодлогод оролцогч, шинжээчдээс авах судалгаа” – ны ажлыг зохион байгуулахад санхүүжилт олгож судалгааны арга зүйн зөвлөгөө өгсөн “Авлигатай тэмцэх газар”-ын хамт олонд, мөн судалгааны тоон мэдээлэл цуглуулахад хамтран ажилласан төрийн байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнууд, судалгааны тоон мэдээлэл цуглуулалтад хамтран ажилласан байгууллага, хувь хүмүүст талархлаа илэрхийлье.

ХУРААНГУЙ

Бодлогод оролцогч, шинжээчдийн үнэлгээг авлигын талаарх төсөөлөл, бодит тохиолдлын 11 үзүүлэлт (төрийн албан хаагчдын үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал, ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал, бусдад хууль бусаар давуу байдал олгох, нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал, бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал, нэмэлт төлбөр болон бэлэг, хандив, санхүүгийн тусламж, үнэ бүхий зүйл өгсөн талаар сонссон болон бусдаас авсан талаар сонссон байдал), авлигыг хянах механизмын 3 үзүүлэлт (авлигыг дотоод механизмаараа илрүүлж, хариуцлага тооцдог байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал, шударга ёсыг бэхжүүлэх авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилласан байдлын үр дүн), удирдлагын хүсэл эрмэлзлийн 2 үзүүлэлт (удирдлагын болон дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл) нийт 3 бүлгийн 16 үзүүлэлтээс бүрддэг.

Судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг 2025 оны 05 сарын 20-оос 2025 оны 07 сарын 20-ны хооронд нийт 2 сарын хугацаанд амжилттай зохион байгууллаа. Мэдээлэл цуглуулалтын ажилд Улаанбаатар хот болон 21 аймгийн хэмжээнд нийт 6 багийн 23 хүн ажилласан.

Төрийн байгууллагуудын шударга байдлын 2025 оны судалгаанд яам, агентлагууд, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын бодлогод оролцогч 1530 шинжээчдийн хамруулсан бөгөөд нийт бодлогод оролцогч, шинжээчдийн 33.2 хувийг төрийн албан хаагч, 24.4 хувийг төрийн бус байгууллагын төлөөлөл, 15.7 хувийг хувийн хэвшил, холбоодын төлөөлөл, 7.1 хувийг эрдэмтэн, судлаачид, 2.2 хувийг бодлого боловсруулагч, 3.3 хувийг хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, 4.2 хувийг аудитор, хяналтын ажилтан, 9.9 хувийг бусад салбарын төлөөлөл тус тус эзэлж байна.

БОУ нь 2025 онд 71.8 оноо болж, 2024 онтой харьцуулахад (4.8↑) оноогоор дээшилж үнэлэгдсэн бөгөөд авлигын талаарх төсөөлөл (7.9↑) оноогоор, авлигыг хянах механизм (2.2↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (3.9↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (5.1↑) оноогоор тус тус өссөн нь нөлөөлжээ.

Яамдын БОУ нь 71.1 оноо болж (2.6↑) оноогоор, агентлагуудын БОУ нь 73.9 оноо болж (3.9↑) оноогоор, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ нь 70.1 оноо болж (7.9↑) оноогоор, дүүргүүдийн БОУ нь 72.6 болж (7.0↑) тус тус өсөж үнэлэгдсэн сайн үзүүлэлттэй үнэлэгдлээ.

Яамдын БОУ өсөж үнэлэгдэхэд яамдын авлигын талаарх төсөөлөл (7.6↑), оноогоор, авлигыг хянах механизм (2.1↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (1.4↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (4.6↑) оноогоор тус тус өссөн нь нөлөөлжээ. Авлигын талаарх төсөөллийн үнэлгээ нь Эдийн засаг, хөгжлийн яам (40.6↑) оноогоор, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам (27.8↑) оноогоор өссөн байв. Харин авлигын бодит тохиолдлын үнэлгээгээр Боловсрол, шинжлэх ухааны яам (30.4↓) оноогоор, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (22.6↓) оноогоор буурсан байгааг анхаарах шаардлагатай нь судалгааны үр дүнгээс тодорхой байна.

Агентлагуудын БОУ өмнөх оноос (3.9↑) оноогоор өсөж үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөлөл (7.6↑) оноогоор, ажлыг хянах механизм (2.1↑) оноогоор, авлигын бодит

тохиолдол (1.4↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (4.6↑) оноогоор тус тус өсөж үнэлэгдсэн нь нөлөөлсөн.

Агентлагуудаас “Төрийн худалдан авах ажиллагааны газар”-ын хувьд 2025 онд БОУ хамгийн ихээр буюу (21.9↑) оноогоор нэмэгдэхэд тухайн байгууллагын авлигыг хянах механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл сайжирсантай холбоотой. Харин Шүүх шинжилгээний ерөнхий газрын хувьд 2025 онд БОУ хамгийн ихээр буурч буюу (24.5↓) оноогоор буурсан. Иймд авлигын талаарх төсөөлөл, авлигын бодит тохиолдлын шударга байдал хамгийн ихээр бууруулахад анхаарах хэрэгтэй.

Аймаг, нийслэлийн БОУ өмнөх оноос (7.9↑) оноогоор өсөж үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөлөл (9.9↑) оноогоор, ажлыг хянах механизм (4.2↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (8.1↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (9.4↑) оноогоор тус тус өсөж үнэлэгдсэн нь нөлөөлжээ. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ-ний хувьд 2025 онд 70.1 оноотой болж, өмнөх онтой харьцуулахад (7.9↑) оноогоор өсөж үнэлэгджээ. Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын БОУ хамгийн ихээр буюу (35.5↑) оноогоор, Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын БОУ (30.7↑) оноогоор тус тус өссөн. Харин Архангай аймгийн ЗДТГ-ын үнэлгээ хамгийн ихээр буурсан буюу (17.4↓) оноогоор буурч үнэлэгдсэн байна.

Дүүргүүдийн ЗДТГ-ын БОУ өмнөх оноос 7.0 оноогоор өсөж үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөлөл (11.1↑) оноогоор, ажлыг хянах механизм (3.0↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (6.3↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (7.6↑) оноогоор тус тус өсөж үнэлэгдсэн нь нөлөөлжээ.

БОУ-гээр хамгийн өндөр оноо авсан байгууллагууд нь Баянгол дүүргийн ЗДТГ, Оюуны өмчийн газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Төв аймгийн ЗДТГ, Дорноговь аймгийн ЗДТГ, Стандарт, хэмжил зүйн газрууд байна. Эдгээрээс Баянгол дүүргийн ЗДТГ хамгийн өндөр буюу 88.8 оноотой үнэлэгдэж тэргүүлсэн.

БОУ хамгийн бага үнэлэгдсэн байгууллагууд нь Шүүх шинжилгээний ерөнхий газар, Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ, Архангай аймгийн ЗДТГ, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам байна. Эдгээрээс Боловсрол, шинжлэх ухааны яам хамгийн бага буюу 44.2 оноотой үнэлэгдэж сүүлд эрэмбэлэгдсэн байна. Хамгийн бага оноотой үнэлэгдсэн 5 байгууллагын БОУ-ний дундаж нь улсын дундаж БОУ-нээс (8.1↓) оноогоор доогуур үнэлэгджээ.

Монгол улсад авлига хамгийн их тархсан 5 институцээр “Шүүхийн байгууллага”, “Газрын алба”, “Улс төрийн нам”, “Төрийн захиргааны яам, агентлаг”, “Гаалийн байгууллага” байна. Уг үзүүлэлтийг 2024 онтой харьцуулбал, “Эрүүл мэндийн байгууллага”-ын үзүүлэлт өмнөх оноос гурван байраар сайжирч авлига хамгийн их тархсан 5 институцэд багтаагүй ч эхний 6 байгууллагад байна. Өнгөрсөн жил 7 дугаарт эрэмбэлэгдэж байсан “Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг” нь 2025 онд эхний 4 дүгээрт эрэмбэлэгджээ.

Авлигаас урьдчилан сэргийлэх, бууруулахын тулд авлига, ашиг сонирхлын талаарх хуулийн мэдээллээр хангах, төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах, цалин хөлс, хангамж, орлогыг нэмэгдүүлэх, улс төрөөс бизнесийн бүлэглэлийг ангид байлгах, хяналтыг сайжруулах (байгууллагын дотоод хяналт, хараат бус хяналт, аудиторын үйл ажиллагааг сайжруулах) ажлуудыг зохион байгуулах шаардлагатай нь судалгаагаар батлагдлаа.

Авлигын шалтгаан, нөхцөлүүд цалин хөлс бага 16.8 хувь, ажилгүйдэл, ядуурал, амьжиргааны түвшин, үнийн өсөлт 11.7 хувь, хувь хүний хандлага, шунал, ёс зүй 7.7 хувь, хүнд суртал их 7.1 хувь, эрх мэдлээ урвуулан ашиглах, эрх мэдэл төвлөрөл 5.0 хувиар

эрэмбэлэгдсэн тул цаашид авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд эдгээр шалтгаан, нөхцөлийг харгалзан үзэхийг санал болгож байна.

БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1.1.Шударга байдлын үнэлгээний аргачлал

1.1.1. Судалгааны зорилго, зорилт


Судалгааны зорилго нь “Төрийн байгууллагын шударга байдлын талаар бодлогод оролцогч, шинжээчдээс авах судалгаа”-ны асуулга, зааврын дагуу мэдээллийг цуглуулах, цуглуулсан мэдээлэлд үндэслэн тооцооллыг хийж, бодлогод оролцогчдын үнэлгээний тайлан болон шударга байдлын үнэлгээний нэгдсэн тайланг боловсруулж, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд оршино. Энэхүү судалгааны зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Авлигын талаарх төсөөлөл, авлигын хяналт болон авлигын бодит тохиолдлыг тодорхойлж, Монгол Улс дахь авлигыг үнэлэх;
- Шударга ёсыг бэхжүүлэх, авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгаан нөхцөлийг арилгах, авлигыг таслан зогсоох болон төрийн байгууллагаас авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг суурь мэдээллээр хангах;
- Шударга байдлыг байгууллагын түвшинд тооцсоноор тухайн байгууллагын шударга байдлын үнэлгээг нэмэгдүүлэхэд зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлох;
- Шударга байдлын үнэлгээний үр дүнг олон нийтэд мэдээлэх замаар төрийн байгууллагын зүгээс үнэлгээний үр дүнг сайжруулах хүсэл зоригийг нэмэгдүүлэх, авлигыг бууруулах санал, санаачилга өрнүүлэх.

1.1.2. Үнэлгээний загвар

Бодлогод оролцогчдын үнэлгээнд авлигын талаарх төсөөлөл, бодит тохиолдол болон авлигыг хянах механизм, удирдлагын хүсэл эрмэлзлийн нийт 16 үзүүлэлт багтана.

Зураг 1. Үнэлгээний загвар



Эх үүсвэр: Судалгааны баг

Шударга байдлын үнэлгээний утга:

Шударга байдлын үнэлгээг 0-100 хүртэлх оноогоор гаргадаг бөгөөд үнэлгээний утга 100-тай тэнцүү бол хамгийн шударгыг илэрхийлнэ. Шударга байдлын үнэлгээ болон түүнийг бүрдүүлэгч үнэлгээний үзүүлэлтүүдийг дараах байдлаар тооцно.

Бодлогод оролцогч, шинжээчдийн үнэлгээ:

$$P_i = \frac{A_i + B_i + C_i}{3}$$

Энд, P_i - i -р байгууллагын бодлогод оролцогчдын үнэлгээ, A_i - авлигын талаарх төсөөллийн оноо, B_i - авлигын хяналтын оноо, C_i - авлигын хяналтын бодит тохиолдлын тоо

Шударга байдлын үнэлгээний судалгаанд ашиглагдаж буй асуулт бүрийг үнэлгээнд үзүүлэлт болгон хамруулахдаа дараах 2 аргын аль тохирохыг ашиглана. Үүнд:

- Хариулагчийн хувийн үнэлгээнд үндэслэн оноожуулах эсвэл
- Байгууллагын үнэлгээнд үндэслэн оноожуулах

Хариулагчийн хувийн үнэлгээнд үндэслэн оноожуулахдаа 1-5 хүртэл хэмжээс бүхий Лайкертын хэмжээс бүхий хариултыг шударга байдлын үнэлгээний 0-100 хүртэлх хэмжээст шилжүүлэх ба дараах загварыг баримтална. Хэрвээ тухайн хариулт эерэг утгатай бол 100, сөрөг утгатай бол 0 оноог өгнө.

Хүснэгт 1. 1-5 хүртэл хэмжээс бүхий хариултыг ШБҮ-ний 0-100 оноонд шилжүүлэх нь

Хариулт	5 оноо	Шилжүүлэх оноо
Ихээхэн түгээмэл	1	0 эсвэл 100
Түгээмэл	2	25 эсвэл 75
Дунд зэрэг	3	50
Бага зэрэг	4	75 эсвэл 25
Огт байхгүй	5	100 эсвэл 0

Эх үүсвэр: Судалгааны баг

Үзүүлэлтийн дундаж оноог тооцохдоо тухайн байгууллагын судалгаанд оролцсон хүмүүсийн хариулсан онооны байдалд нь үндэслэн байгууллагын дундаж оноог тооцно. Дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.


$$\text{Үзүүлэлтийн дундаж оноо} = \frac{\text{Тухайн үзүүлэлтийн нийт онооны нийлбэр}}{\text{Тухайн байгууллагын судалгаанд хамрагдсан хүний тоо}}$$

Байгууллагын үнэлгээнд үндэслэн оноожуулах: Хариулагчийн хувийн үнэлгээгээр тооцох боломжгүй, давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтийн үнэлгээг гаргахдаа бусад байгууллагатай харьцуулах замаар буюу байгууллагын ерөнхий үнэлгээгээр тооцно.

1.2. Судалгааны хамрах хүрээ

“Төрийн байгууллагуудын бодлогод оролцогчид, шинжээчдээс шударга байдлын үнэлгээ”-ний судалгаанд 16 яам, 34 агентлаг, 21 аймгийн ЗДТГ, Нийслэл, дүүргийн ЗДТГ-10 нийт 81 байгууллагын 1530 бодлогод оролцогч, шинжээчдийн төлөөллөөс судалгааны тоон мэдээллийг цуглууллаа. Түүврийн хэмжээг дараах схемээр харуулав.

Зураг 2. Түүврийн хамрах хүрээ, түүврийн хэмжээ




Яамны түвшинд бодлого боловсруулахад оролцсон 400 шинжээч, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагын түвшинд бодлого боловсруулахад оролцсон 680 шинжээч, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын түвшинд бодлого боловсруулахад оролцсон 450 шинжээч нийт 1530 бодлогод оролцогч, шинжээчдийн төлөөллийг судалгаанд хамрууллаа. (Түүврийн дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу).

1.3 Судалгааны мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалт

Судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг 2025 оны 05 сарын 20-оос 2025 оны 07 сарын 20-ны хооронд нийт 2 сарын хугацаанд амжилттай зохион байгууллаа. Мэдээлэл цуглуулалтын ажилд Улаанбаатар хот болон 21 аймгийн хэмжээнд нийт 6 багийн 25 хүн ажилласан.

Судалгааны багийн гишүүд нь судалгаа хэрхэн авах талаарх аргазүйн сургалтад хамрагдаж, мэдээлэл цуглуулах ажлыг талбар дээр нь гүйцэтгэн ажилласан болно. Судалгааны тоон мэдээлэл цуглуулалтын үйл явцыг тухайн төрийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэд, аж ахуйн нэгж болон өмнө нь үйлчлүүлсэн иргэд, аж ахуйн нэгж, шинжээчдийг хамруулав.

Зураг 3. Мэдээлэл цуглуулах багийн зохион байгуулалт



Эх үүсвэр: Судалгааны баг

БҮЛЭГ 2. БОДЛОГОД ОРОЛЦОГЧ, ШИНЖЭЭЧДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

2.1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээний бодлогод оролцогч, шинжээчдээс авах судалгаанд нийт 1530 бодлогод оролцогч, шинжээчдийг хамруулсан.

Хүснэгт 2. Судалгаанд оролцсон бодлогод оролцогч, шинжээчийн төлөөлж буй хүрээ

№	Шинжээчийн төлөөлж буй хүрээ	Оролцогчдын тоо	Эзлэх хувь
1	Төрийн албан хаагч	508	33.2%
2	Төрийн бус байгууллага	374	24.4%
3	Хувийн хэвшил, холбоодын төлөөлөл	240	15.7%
4	Эрдэмтэн, судлаач	108	7.1%
5	Аудитор, хяналтын ажилтан	65	4.2%
6	Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч	50	3.3%
7	Бодлого боловсруулагч	33	2.2%
8	Бусад	152	9.9%
Нийт дүн		1530	100%

Эх үүсвэр: Судалгааны баг


Шинжээчийн төлөөлж буй хүрээгээр авч үзвэл судалгаанд оролцогчдын 33.2 хувь нь төрийн албан хаагч, 24.4 хувь нь төрийн бус байгууллага, 15.7 хувь нь хувийн хэвшил, холбоодын төлөөлөл, 7.1 хувь нь эрдэмтэн, судлаач, 2.2 хувь нь бодлого боловсруулагч, 3.3 хувь нь хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, 4.2 хувь нь аудитор, хяналтын ажилтан, 9.9 хувь нь бусад салбарыг тус тус төлөөлж байна.

2.2 Бодлогод оролцогч, шинжээчдийн үнэлгээний ерөнхий үр дүн

Төрийн байгууллагын бодлогод оролцогч, шинжээчдийн үнэлгээ (БОУ) нь тухайн байгууллагын авлигын талаарх төсөөллийн 9 үзүүлэлт (тухайн байгууллагын авлигын түгээмэл байдал, албан хаагчдын төрийн үйлчилгээг үзүүлэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх явдал, ах дүү танил талынхаа нөлөөнд автах явдал, бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал, нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийгүй ёстой үйлдлийг хийх явдал, бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал), авлигын хяналтын 3 үзүүлэлт (дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал, шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үр дүнтэй байдал), авлигын бодит тохиолдлын 2 үзүүлэлт (тухайн байгууллагын алба хаагчдад та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс нь нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж өгсөн явдал, бусад этгээдээс нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж өгсөн явдал), удирдлагын авлигатай тэмцэх хүслийн 2 үзүүлэлт (удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл, дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл) зэрэг үзүүлэлтүүдийн дунджаар тодорхойлогддог.

БОУ нь 2025 онд 71.8 оноо болж, 2024 онтой харьцуулахад (4.8↑) оноогоор дээшилж үнэлэгдсэн бөгөөд авлигын талаарх төсөөлөл (7.9↑) оноогоор, авлигыг хянах механизм (2.2↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (3.9↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (5.1↑) оноогоор тус тус өссөн нь нөлөөлжээ.

Зураг 4. БОУ, байгууллагын төрлөөр



Эх үүсвэр: Судалгааны баг

БОУ-г байгууллагын төрлөөр 2024 онтой харьцуулахад, яамдын БОУ нь 69.5 оноо болж (0.9↑) оноогоор, агентлагуудын БОУ нь 73.9 оноо болж (3.9↑) оноогоор, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ нь 70.1 оноо болж (7.9↑) оноогоор, дүүргүүдийн БОУ нь 72.6 болж (7.0↑) тус тус өсөж үнэлэгдсэн байна.

Яамдын БОУ өсөж үнэлэгдэхэд яамдын авлигын талаарх төсөөлөл (7.6↑) оноогоор, авлигыг хянах механизм (2.1↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (1.4↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (4.6↑) оноогоор тус тус өссөн нь нөлөөлжээ. Авлигын талаарх төсөөллийн үнэлгээ нь Эдийн засаг хөгжлийн яам (40.6↑) оноогоор, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам (27.8↑) оноогоор өссөн байв. Мөн авлигыг хянах механизмын үнэлгээгээр Барилга, хот байгуулалтын яам (22.4↑) оноогоор, Эдийн засаг хөгжлийн яам (19.9↑) оноогоор дээшилж, авлигын бодит тохиолдлын үнэлгээгээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам (48.5↑) оноогоор, Эдийн засаг хөгжлийн яам (21.8↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэлд өгсөн үнэлгээгээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (21.8↑) оноогоор, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам (18.9↑) оноогоор өсөлттэй үнэлэгдсэн нь яамдын үнэлгээ өсөхөд чухал нөлөө үзүүлжээ.

Харин яамдын БОУ өмнөх оноос буурахад голчлон нөлөө үзүүлсэн байгууллагуудыг дурдвал: авлигын талаарх төсөөлөл нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (27.6↓) оноогоор, Хууль зүй, дотоод хэргийн яам (27.4↓) оноогоор, авлигыг хянах механизм нь Хууль зүй, дотоод хэргийн яам (39.3↓) оноогоор, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (16.6↓) оноогоор буурсан. Авлигын бодит тохиолдлын үнэлгээгээр Боловсрол, шинжлэх ухааны яам (30.4↓) оноогоор, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (22.6↓) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл үнэлгээгээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (30.2↓) оноогоор, Хууль зүй, дотоод хэргийн яам (24.2↓) оноогоор тус тус буурсан нь яамдын үнэлгээнд сөрөг нөлөөг хүчтэй үзүүлжээ. (дэлгэрэнгүйг яамдын БОУ-ний үр дүн хэсгээс харна уу).

Агентлагуудын БОУ өмнөх оноос (3.9↑) оноогоор өсөж үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөлөл (7.6↑) оноогоор, ажлыг хянах механизм (2.1↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (1.4↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (4.6↑) оноогоор тус тус өсөж үнэлэгдсэн нь нөлөөлсөн.

Агентлагуудын БОУ нь өмнөх оноос буурсан байгууллагуудыг дурдвал, авлигын талаарх төсөөллийн үнэлгээ Жижиг, дунд үйлдвэрийн газар (39.0↓) оноогоор, Шүүх шинжилгээний ерөнхий газар (28.0↓) оноогоор, авлигыг хянах механизмын үнэлгээгээр Шүүх шинжилгээний ерөнхий газар (19.3↓) оноогоор, Гадаадын иргэн харьяатын газар (17.2↓) оноогоор буурсан. Авлигын бодит тохиолдлын үнэлгээ нь Шүүх шинжилгээний ерөнхий газар (32.2↓) оноогоор, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар (17.6↓) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл Жижиг, дунд үйлдвэрийн газар (27.0↓) оноогоор, Мал эмнэлгийн ерөнхий газар (26.2↓) оноогоор буурсан нь агентлагуудын үнэлгээнд сөрөг нөлөөг үзүүлжээ. (дэлгэрэнгүйг агентлагийн БОУ-ний үр дүн хэсгээс харна уу).

Аймаг, нийслэлийн БОУ өмнөх оноос (7.9↑) оноогоор өсөж үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөлөл (9.9↑) оноогоор, ажлыг хянах механизм (4.2↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (8.1↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (9.4↑) оноогоор тус тус өсөж үнэлэгдсэн нь нөлөөлжээ.

Аймаг, нийслэлийн БОУ үнэлгээнд сөрөг нөлөө үзүүлсэн үзүүлэлтүүдийг дурдвал, авлигын талаарх төсөөллийн үнэлгээ Баян-Өлгий аймгийн ЗДТГ (14.1↓) оноогоор, Нийслэлийн ЗДТГ (8.8↓) оноогоор, авлигыг хянах механизмын үнэлгээ, Архангай аймгийн ЗДТГ (24.2↓) оноогоор, Булган аймгийн ЗДТГ (11.4↓) оноогоор буурсан. Авлигын бодит тохиолдлын үнэлгээ Архангай аймгийн ЗДТГ (31.5↓) оноогоор, Баян-Өлгий аймгийн ЗДТГ (15.5↓) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл Архангай аймгийн ЗДТГ (5.6↓) оноогоор, Булган ба Дорноговь аймгуудын ЗДТГ тус бүр (4.2↓) оноогоор буурсан нь аймаг, нийслэлийн үнэлгээнд сөрөг нөлөө үзүүлжээ. (дэлгэрэнгүйг аймаг, нийслэлийн БОУ-ний үр дүн хэсгээс харна уу).

Дүүргүүдийн ЗДТГ-ын БОУ өмнөх оноос (7.0↑) оноогоор өсөж үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөлөл (11.1↑) оноогоор, ажлыг хянах механизм (3.0↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (6.3↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (7.6↑) оноогоор тус тус өсөж үнэлэгдсэн нь нөлөөлжээ.

Дүүргүүдийн БОУ үнэлгээнд сөрөг нөлөө үзүүлсэн нь авлигын талаарх төсөөллийн үнэлгээ Хан-Уул дүүргийн ЗДТГ (11.6↓) оноогоор, Баянзүрх дүүргийн ЗДТГ (1.7↓) оноогоор, авлигыг хянах механизмын үнэлгээ Багахангай дүүргийн ЗДТГ (35.5↓) оноогоор, Багануур дүүргийн ЗДТГ (5.8↓) оноогоор буурсан. Авлигын бодит тохиолдлын үнэлгээний хувьд Баянзүрх дүүргийн ЗДТГ (7.1↓) оноогоор, Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ (2.0↓) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэлд өгсөн үнэлгээний хувьд Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ (8.3↓) оноогоор, Багахангай дүүргийн ЗДТГ (8.1↓) оноогоор тус тус буурсан нь дүүргүүдийн үнэлгээнд сөрөг нөлөө үзүүлжээ. (дэлгэрэнгүйг дүүргүүдийн БОУ-ний үр дүн хэсгээс харна уу).

2.2.1 БОУ хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд

БОУ-гээр хамгийн өндөр оноо авсан байгууллагууд нь Баянгол дүүргийн ЗДТГ, Оюуны өмчийн газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Төв аймгийн ЗДТГ, Дорноговь аймгийн ЗДТГ, Стандарт, хэмжил зүйн газрууд байна. Эдгээрээс Баянгол дүүргийн ЗДТГ хамгийн өндөр буюу 88.8 оноотой үнэлэгдэж тэргүүлсэн.

Хүснэгт 3. БОУ, хамгийн өндөр болон хамгийн бага оноо авсан байгууллагууд

№	Байгууллагын нэр	2024 оны эрэмбэ	2025 оны эрэмбэ	2024 оны оноо	2025 оны оноо	Үнэлгээний өөрчлөлт
Хамгийн өндөр үнэлгээтэй:						
1	Баянгол дүүргийн ЗДТГ	52	1	62.0	88.8	26.8↑
2	Оюуны өмчийн газар	5	2	80.9	88.2	7.3↑

3	Төрийн худалдан авах ажиллагааны газар	50	3	63.9	85.8	21.9↑
4	Төв аймгийн ЗДТГ	4	4	84.3	83.8	0.5↓
5	Дорноговь аймгийн ЗДТГ	8	5	79.8	83.0	3.2↑
6	Стандарт, хэмжил зүйн газар	11	5	76.9	83.0	6.1↑
Хамгийн бага үнэлгээтэй:						
77	Шүүх шинжилгээний ерөнхий газар	10	77	78.1	53.7	24.4↓
78	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	66	78	52.4	53.7	1.3↑
79	Архангай аймгийн ЗДТГ	36	79	68.6	51.2	17.4↓
80	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	30	80	70.5	46.3	24.2↓
81	Боловсрол, шинжлэх ухааны яам	69	81	49.2	44.2	5.0↓

Эх үүсвэр: Судалгааны баг

Оюуны өмчийн газар, Төв аймгийн ЗДТГ нь өмнөх оны үнэлгээгээр ч мөн адил эхний байранд жагсаж байжээ. Гэсэн хэдий ч Төв аймгийн ЗДТГ-ын үнэлгээ өмнөх оноос (0.5↓) оноогоор буурсан. Хамгийн өндөр оноотой үнэлэгдсэн 5 байгууллагын дундаж БОУ нь улсын дундаж БОУ-ээс (13.6↑) оноогоор өндөр байгаа бол, 2024 онтой харьцуулахад (10.8↑) оноогоор өсөж үнэлэгджээ.

Хамгийн өндөр оноотой 5 байгууллагын хувьд авлигыг хянах механизм хамгийн бага буюу 72.3 оноотой үнэлэгдсэн бол авлигын бодит тохиолдол хамгийн өндөр буюу 100.0 оноотой үнэлэгдсэн байна.

Хүснэгт 4. БОУ, хамгийн өндөр оноо авсан 5 байгууллагын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ

№	Байгууллагын нэр	2025 оны БОУ оноо	Дэд үзүүлэлтийн үнэлгээ				БОУ, өөрчлөлт, өмнөх оноос өөрчлөгдсөн оноо
			Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	
1	Баянгол дүүргийн ЗДТГ	88.8	86.0	84.7	100.0	84.4	26.8↑
2	Оюуны өмчийн газар	88.2	97.2	76.1	100.0	79.6	7.3↑
3	Төрийн худалдан авах ажиллагааны газар	85.8	85.0	74.0	100.0	84.4	21.9↑
4	Төв аймгийн ЗДТГ	83.8	90.3	68.3	100.0	76.8	0.5↓
5	Дорноговь аймгийн ЗДТГ	83.0	93.2	64.1	100.0	74.9	3.2↑
6	Стандарт, хэмжил зүйн газар	83.0	93.0	66.4	100.0	72.6	6.1↑
Дундаж		85.4	90.8	72.3	100.0	78.8	10.8↑

Эх үүсвэр: Судалгааны баг

Хамгийн өндөр оноотой үнэлэгдсэн “Баянгол дүүргийн ЗДТГ” -ын хувьд авлигын талаарх төсөөлөл 2024 онтой харьцуулахад (27.1↑) оноогоор, авлигыг хянах механизм (31.1↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (22.0↑) оноогоор өссөн бол авлигын бодит тохиолдлын өөрчлөлт (26.7↑) оноогоор өссөн нь ийнхүү ерөнхий оноо өсөхөд нөлөөлжээ.

Хамгийн өндөр үнэлгээтэй байгууллагуудын хувьд БОУ өсөж үнэлэгдэхэд авлигыг хянах механизм түүн дотроо авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал, удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл хамгийн ихээр сайжирсан гэж үзэж болно. Мөн түүнчлэн эдгээр эхний 5

байранд орж, БОУ дээшилсэн байгууллагуудад бүгдэд нь “авлигын бодит тохиолдол”-ын үнэлгээ 100 хувь буюу илрээгүй байв.

БОУ хамгийн бага оноо байгууллагууд нь Шүүх шинжилгээний ерөнхий газар, Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ, Архангай аймгийн ЗДТГ, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам байна. Эдгээрээс Боловсрол, шинжлэх ухааны яам хамгийн бага буюу 44.2 оноотой үнэлэгдэж сүүлд эрэмбэлэгдсэн байна.

Хүснэгт 5. БОУ, хамгийн бага оноо авсан 5 байгууллагын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ

№	Байгууллагын нэр	2025 оны БОУ оноо	Дэд үзүүлэлтийн үнэлгээ				БОУ, өөрчлөлт, өмнөх оноос өөрчлөгдсөн оноо
			Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	
77	Шүүх шинжилгээний ерөнхий газар	53.7	54.2	39.2	64.9	56.4	24.4↓
78	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	53.7	58.2	46.1	68.8	41.7	1.3↑
79	Архангай аймгийн ЗДТГ	51.2	53.7	31.6	68.5	51.3	17.4↓
80	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	46.3	46.8	36.8	65.4	36.0	24.2↓
81	Боловсрол, шинжлэх ухааны яам	44.2	47.0	30.0	61.9	38.1	5.0↓
Дундаж		49.8	53.7	36.7	65.9	44.7	13.9↓

Эх үүсвэр: Судалгааны баг

Хамгийн бага оноотой үнэлэгдсэн 5 байгууллагын БОУ-ний дундаж нь улсын дундаж БОУ-нээс (8.1↓) оноогоор доогуур үнэлэгджээ. Хамгийн бага оноотой үнэлэгдсэн 5 байгууллагын авлигыг хянах механизм нь бусад дэд үзүүлэлттэй харьцуулахад хамгийн бага буюу 36.7, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 44.7 оноотой үнэлэгдсэн байна. 2024 онтой харьцуулахад 5 байгууллагын дунджаар авлигын талаарх төсөөлөл (8.0↓) оноогоор, авлигыг хянах механизм (12.2↓) оноогоор, авлигын бодит тохиолдол (23.7↓) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (11.9↓) оноогоор тус тус буурсан нь нөлөөлсөн бөгөөд үүнээс авлигын талаарх төсөөлөл, авлигыг хянах механизм хамгийн ихээр буурч үнэлэгдсэн нь БОУ буурахад нөлөөлжээ (Дэлгэрэнгүйг 2.4 хэсгээс харна уу).

2.2.2 Яамдын бодлогод оролцогчдын үнэлгээ

Яамдын 2025 оны БОУ нь 69.5 болж 2024 онтой харьцуулахад (0.9↑) оноогоор дээшилж үнэлэгдсэн байна. Эрчим хүчний яам, Эдийн засаг хөгжлийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Соёлын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Эрүүл мэндийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яамдын үнэлгээ дээшилсэн. Харин Батлан хамгаалах яам, Гадаад харилцааны яам, Барилга хот байгуулалтын яам, Зам, тээвэр хөгжлийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам БОУ буурсан. Эдгээрээс Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яамны БОУ хамгийн ихээр буурсан бол Эрчим хүчний яам, Эдийн засаг хөгжлийн яамны БОУ хамгийн ихээр дээшилсэн байна.

Хүснэгт 6. Яамдын БОУ, 2024, 2025 оныг харьцуулсан байдлаар

№	Байгууллагын нэр	2024 оны эрэмбэ	2025 оны эрэмбэ	2024	2025	Өөрчлөлт
1	Эдийн засаг хөгжлийн яам	14	1	57.3	80.2	22.9↑
2	Сангийн яам	7	2	71.1	79.8	8.7↑
3	Батлан хамгаалах яам	2	3	80.0	79.5	0.5↓
4	Соёлын яам	3	4	70.8	77.7	6.9↑
5	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	11	5	61.5	76.4	14.9↑

6	Барилга хот байгуулалтын яам	5	6	84.8	76.4	8.4↓
7	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	6	7	67.8	72.8	5.0↑
8	Эрчим хүчний яам	13	8	45.4	72.2	26.8↑
9	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	16	9	70.5	71.0	0.5↑
10	Гадаад харилцааны яам	4	10	76.3	70.8	5.5↓
11	Эрүүл мэндийн яам	10	11	49.2	67.5	18.3↑
12	Зам, тээвэр хөгжлийн яам	12	12	71.2	66.2	5.0↓
13	Хууль зүй, дотоод хэргийн яам	1	13	65.0	65.8	0.8↑
14	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	8	14	59.1	65.1	6.0↑
15	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	9	15	88.5	46.3	42.2↓
16	Боловсрол, шинжлэх ухааны яам	15	16	78.5	44.2	34.3↓
	Яамдын БОҮ			68.6	69.5	0.9↑

Эх үүсвэр: Судалгааны баг

Яамдын БОҮ дээшилж үнэлэгдэхэд дараах үзүүлэлтүүдийн өсөлт нөлөөлсөн байна. Үүнд: яамдын авлигын талаарх төсөөлөл 2024 онтой харьцуулахад (5.9↑) оноогоор, авлигыг хянах механизм (0.1↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (3.6↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (0.9↑) оноогоор тус тус өссөн нь нөлөөлжээ.

Бодлогод оролцогч, шинжээчид яамдын авлигын талаарх авлигын бодит тохиолдол 96.2 оноотой үнэлэгдсэн нь нь хамгийн их нөлөөлсөн гэж үзэж байна. Яамдын бодлогын үнэлгээний асуултуудыг задалж шинжилбэл, тухайн байгууллагад авлига хэр түгээмэл вэ? гэсэн үзүүлэлт (1.6↑) оноогоор, яамдын албан хаагчдын бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал (3.7↑) оноогоор, ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал (4.5↑) оноогоор, бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал (2.5↑) оноогоор, нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал (4.9↑) оноогоор, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал (1.8↑) оноогоор, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал (4.3↑) оноогоор, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал (9.1↑) оноогоор, дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог явдал (2.0↑) оноогоор өссөн.

Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал (1.7↓) оноогоор, шударга ёсыг бэхжүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал (1.2↓) оноогоор буурсан. Сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн явдал (0) өөрчлөлтгүй. Сүүлийн 12 сарын хугацаанд тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө болон бусад үнэ бүхий зүйл өгсөн явдал (1.7↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (2.1↑) оноогоор дээшилсэн. Дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (2.3↓) оноогоор буурсан. Яамдын албан хаагчдын бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах үзүүлэлт (0.2↑) оноогоор өсөж үнэлэгджээ.

Яамдын БОҮ нь дэд шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээнээс хамаарч буй байдлыг корреляцийн хамаарлаар тооцов.

2.2.3 Агентлагуудын бодлогод оролцогчдын үнэлгээ

Агентлагуудын БОУ 2025 онд 73.9 болж, өмнөх оноос (3.9↑) оноогоор өсөж үнэлэгдсэн байна. Гадаадын иргэн харьяатын газар, Биеийн тамир, спортын улсын хороо, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрууд БОУ (3.2↓-24.5↓) оноогоор буурч үнэлэгдсэн бол бусад агентлагуудын БОУ (0.5↑-31.6↑) оноогоор өссөн эерэг үзүүлэлттэй байна.

Хүснэгт 7. Агентлагуудын БОУ, 2024, 2025 оны харьцуулсан байдлаар

№	Байгууллагын нэр	2024 оны эрэмбэ	2025 оны эрэмбэ	2024	2025	Өөрчлөлт
1	Оюуны өмчийн газар	2	1	80.9	88.2	7.4↑
2	Төрийн худалдан авах ажиллагааны газар	27	2	63.9	85.8	21.9↑
3	Стандарт, хэмжил зүйн газар	5	3	76.9	83.0	6.1↑
4	Боловсролын ерөнхий газар	26	4	65.4	82.7	17.4↑
5	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	1	5	85.9	82.4	3.5↓
6	Ойн газар	18	6	71.3	81.8	10.5↑
7	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	12	7	73.5	81.1	7.6↑
8	Улсын бүртгэлийн ерөнхий газар	10	8	74.7	80.5	5.7↑
9	Соёл урлагийн газар	6	9	76.8	80.0	3.2↑
10	Онцгой байдлын ерөнхий газар	11	10	74.0	79.8	5.8↑
11	Архивын ерөнхий газар	23	11	68.6	79.8	11.2↑
12	Үндэсний геологийн алба	34	12	48.1	79.7	31.6↑
13	Иргэний нисэхийн ерөнхий газар	30	13	59.0	77.7	18.7↑
14	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	14	14	72.5	77.1	4.7↑
15	Татварын ерөнхий газар	20	15	70.0	75.9	5.9↑
16	Усны газар	8	16	75.4	75.5	0.1↑
17	Цагдаагийн ерөнхий газар	16	17	72.2	75.1	2.9↑
18	Гаалийн ерөнхий газар	31	18	55.6	73.1	17.5↑
19	Монополын эсрэг газар	19	19	70.3	72.9	2.6↑
20	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	24	20	67.0	71.7	4.8↑
21	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	22	21	69.2	71.6	2.4↑
22	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	21	22	69.5	70.5	1.0↑
23	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	7	23	76.0	69.9	6.1↓
24	Цаг уур, орчны шинжилгээний газар	29	24	61.3	69.7	8.4↑
25	Ашигт малтмал, газрын тосны газар	33	25	49.1	68.6	19.5↑
26	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	13	26	73.4	68.3	5.1↓
27	Нийгмийн даатгалын ерөнхий газар	25	27	66.5	68.2	1.7↑
28	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	17	28	71.4	68.2	3.2↓
29	Гадаадын иргэн харьяатын газар	9	29	75.2	67.5	7.7↓
30	Жижиг, дунд үйлдвэрийн газар	3	30	80.1	64.4	15.7↓
31	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	28	31	61.6	62.1	0.5↑

№	Байгууллагын нэр	2024 оны эрэмбэ	2025 оны эрэмбэ	2024	2025	Өөрчлөлт
32	Мал эмнэлгийн ерөнхий газар	15	32	72.4	62.6	9.8↓
33	Биеийн тамир, спортын улсын хороо	17	33	71.4	62.0	9.4↓
34	Шүүх шинжилгээний ерөнхий газар	4	34	78.2	53.7	24.5↓
	Агентлагуудын БОУ			69.9	73.9	3.9↑

Эх үүсвэр: Судалгааны баг

Агентлагуудын БОУ-г 2024 онтой харьцуулахад, авлигын талаарх төсөөлөл, авлигыг хянах механизм, авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл зэрэг үзүүлэлтүүд бүгд өсөж үнэлэгдсэн ч нь хамгийн их нөлөөлсөн байна. Эдгээр үзүүлэлтүүд өсөж үнэлэгдэхэд тухайн байгууллагад авлига хэр түгээмэл вэ? гэсэн үзүүлэлт (10.2↑) оноогоор, агентлагуудын албан хаагчдын бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал (5.4↑) оноогоор, ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал (9.5↑) оноогоор, бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал (8.7↑) оноогоор, нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал (7.9↑) оноогоор, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал (8.0↑) оноогоор, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал (6.6↑) оноогоор, албан хаагчдын бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах үзүүлэлт (6.3↑) оноогоор, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал (5.9↑) оноогоор тус тус өссөн.

Дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог явдал (1.4↓) оноогоор буурсан байна. Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал (2.1↑) оноогоор, шударга ёсыг бэхжүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал (5.6↑) оноогоор, сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн явдал (1.2↑) оноогоор, сүүлийн 12 сарын хугацаанд тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө болон бусад үнэ бүхий зүйл өгсөн явдал (1.7↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (4.1↑) оноогоор, дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (5.2↑) оноогоор тус тус өссөн.

Агентлагуудаас “Төрийн худалдан авах ажиллагааны газар”-ын хувьд 2025 онд БОУ хамгийн ихээр буюу (21.9↑) оноогоор нэмэгдэхэд тухайн байгууллагын авлигыг хянах механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл сайжирсантай холбоотой гэж бодлогод оролцогч, шинжээчид үзсэн байна. Өөрөөр хэлбэл, тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл 2024 онтой харьцуулахад (21.9↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (26.0↑) оноогоор тус тус дээшилж үнэлэгджээ.

Харин Шүүх шинжилгээний ерөнхий газрын хувьд 2025 онд БОУ хамгийн ихээр буурч буюу (24.5↓) оноогоор буурсан. Тухайн байгууллагын авлигын бодит тохиолдол (32.1↓) оноогоор, авлигын талаарх төсөөлөл (28.0↓) оноогоор, авлигыг хянах механизм (19.4↓) удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (18.6↓) оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ. Өөрөөр хэлбэл, бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар авлигын талаарх төсөөлөл, авлигын бодит тохиолдлын шударга байдал хамгийн ихээр буурсан гэж үнэлсэн байна.

Шүүх шинжилгээний ерөнхий газрын БОУ-г дэлгэрүүлж авч үзвэл, тухайн байгууллагад авлига хэр түгээмэл вэ? гэсэн үзүүлэлт (10.8↓) оноогоор, агентлагуудын албан хаагчдын бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал (37.8↓) оноогоор, ах дүү, танил

талынхаа нөлөөнд автах байдал (21.8↓) оноогоор, бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал (7.2↓) оноогоор, нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал (44.5↓) оноогоор, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал (30.3↓) оноогоор, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал (33.9↓) оноогоор, албан хаагчдын бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах үзүүлэлт (31.4↓) оноогоор, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал (34.1↓) оноогоор, дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог явдал (29.5↓) оноогоор, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал (8.8↓) оноогоор, шударга ёсыг бэхжүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал (19.9↓) оноогоор, сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн явдал (33.3↓) оноогоор, сүүлийн 12 сарын хугацаанд тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө болон бусад үнэ бүхий зүйл өгсөн явдал (31.0↓) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (20.3↓) оноогоор, дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (17.0↓) оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ.

2.2.4 Аймаг, нийслэлийн бодлогод оролцогчдын үнэлгээ

Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ-ний хувьд 2025 онд 70.1 оноотой болж, өмнөх онтой харьцуулахад (7.9↑) оноогоор өсөж үнэлэгджээ. Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын БОУ хамгийн ихээр буюу (35.5↑) оноогоор, Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын БОУ (30.7↑) оноогоор тус тус өссөн. Харин Архангай аймгийн ЗДТГ-ын үнэлгээ хамгийн ихээр буурсан буюу (17.4↓) оноогоор буурч үнэлэгдсэн байна.

Аймаг, нийслэлийн БОУ өсөж үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Тухайлбал, авлигын талаарх төсөөлөл (9.9↑) оноогоор, авлигыг хянах механизм (4.2↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (8.1↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (9.4↑) оноогоор тус тус өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 8. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ, 2024, 2025 оныг харьцуулсан байдлаар

№	Байгууллагын нэр	2024 оны эрэмбэ	2025 оны эрэмбэ	2024	2025	Өөрчлөлт
1	Төв аймгийн ЗДТГ	1	1	84.3	83.8	0.5↓
2	Дорноговь аймгийн ЗДТГ	2	2	79.9	83.0	3.1↑
3	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	9	3	65.4	82.8	17.4↑
4	Хөвсгөл аймгийн ЗДТГ	8	4	66.8	82.5	15.7↑
5	Сүхбаатар аймгийн ЗДТГ	20	5	48.0	78.7	30.7↑
6	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	22	6	40.3	75.8	35.5↑
7	Говь-Алтай аймгийн ЗДТГ	18	7	54.2	75.3	21.1↑
8	Нийслэлийн ЗДТГ	3	8	75.1	73.7	1.4↓
9	Завхан аймгийн ЗДТГ	14	9	57.4	73.1	15.7↑
10	Өвөрхангай аймгийн ЗДТГ	4	10	72.5	71.7	0.8↓
11	Увс аймгийн ЗДТГ	12	11	62.8	70.9	8.1↑
12	Дундговь аймгийн ЗДТГ	13	12	61.7	69.4	7.7↑
13	Орхон аймгийн ЗДТГ	10	13	65.1	68.4	3.3↑
14	Булган аймгийн ЗДТГ	5	14	70.4	67.9	2.5↓
15	Хэнтий аймгийн ЗДТГ	16	15	56.2	66.5	10.3↑
16	Өмнөговь аймгийн ЗДТГ	11	16	64.1	65.8	1.7↑
17	Баянхонгор аймгийн ЗДТГ	21	17	44.8	63.6	18.8↑

18	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	7	18	67.3	63.3	4.0↓
19	Дархан-Уул аймгийн ЗДТГ	15	19	56.4	61.7	5.3↑
20	Ховд аймгийн ЗДТГ	17	20	54.4	57.0	2.6↑
21	Дорнод аймгийн ЗДТГ	19	21	52.2	55.6	3.4↑
22	Архангай аймгийн ЗДТГ	6	22	68.6	51.2	17.4↓
	Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ			62.2	70.1	7.9↑

Эх үүсвэр: Судалгааны баг

Тухайн байгууллагад авлига хэр түгээмэл вэ? гэсэн хариулт (10.0↑) оноогоор, агентлагуудын албан хаагчдын бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал (11.9↑) оноогоор, ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал (9.9↑) оноогоор, бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал (8.8↑) оноогоор, нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал (12.2↑) оноогоор, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал (13.0↑) оноогоор, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал (11.1↑) оноогоор, албан хаагчдын бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах үзүүлэлт (1.0↑) оноогоор, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал (11.5↑) оноогоор, дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог явдал (7.2↑) оноогоор, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал (2.6↑) оноогоор, шударга ёсыг бэхжүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал (2.8↑) оноогоор, сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн явдал (8.4↑) оноогоор, сүүлийн 12 сарын хугацаанд тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө болон бусад үнэ бүхий зүйл өгсөн явдал (7.7↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (10.2↑) оноогоор, дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (8.7↑) оноогоор тус тус өссөн нь нөлөөлжээ.

Төв аймгийн ЗДТГ-ын авлигын талаарх төсөөлөл 2024 онтой харьцуулахад (0.5↓) оноогоор буурсан хэдий ч энэ онд дахин нэгдүгээр байранд орсон хэвээр байна. Гэхдээ тус аймгийн ЗДТГ өмнөх оноос буурсан үзүүлэлтүүд болох авлигын талаар төсөөлөл (5.4↓), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (2.9↓) буурсан үзүүлэлтүүдийг анхаарах хэрэгтэй юм. Бодлогод оролцогч, шинжээчдийн хувьд, ерөнхийд нь Төв аймгийн ЗДТГ-ын авлигыг хянах механизм сайн байна гэж үзжээ.

Хамгийн сүүлд эрэмбэлэгдсэн Архангай аймгийн ЗДТГ-ын хувьд, БОУ нь 2025 онд хамгийн ихээр буурсан буюу (17.4↓) оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд авлигын талаарх төсөөлөл 2024 онтой харьцуулахад (8.3↓) оноогоор, авлигыг хянах механизм (24.2↓) оноогоор, авлигын бодит тохиолдол (31.5↓) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (5.5↓) оноогоор тус тус буурсан нь нөлөөлсөн байна. Тухайлбал, тус аймгийн хувьд авлигын бодит тохиолдол хамгийн их нэмэгджээ.

Тухайн байгууллагын БОУ-г дэлгэрүүлж авч үзвэл, тухайн байгууллагад авлига хэр түгээмэл вэ? гэсэн үзүүлэлт (13.3↓) оноогоор, агентлагуудын албан хаагчдын бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал (3.3↓) оноогоор, ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал (13.3↓) оноогоор, бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал (10.3↓) оноогоор, нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал (1.1↓) оноогоор, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал (14.2↓) оноогоор, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал (11.6↓) оноогоор буурсан байна. Харин албан хаагчдын бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах үзүүлэлт (5.0↑) оноогоор дээшилсэн. Албаны мэдээллийг

хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусад дамжуулах явдал (12.5↓) оноогоор, дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог явдал (36.3↓) оноогоор, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал (16.7↓) оноогоор, шударга ёсыг бэхжүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал (19.6↓) оноогоор, сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн явдал (26.7↓) оноогоор, сүүлийн 12 сарын хугацаанд тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө болон бусад үнэ бүхий зүйл өгсөн явдал (36.4↓) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (17.5↓) оноогоор буурчээ. Дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (6.4↑) оноогоор дээшилсэн байна.

2.2.5 Дүүргүүдийн бодлогод оролцогчдын үнэлгээний үр дүн

Дүүргүүдийн БОУ нь 2025 онд 72.6 оноо болж, 2024 онтой харьцуулахад (7.0↑) оноогоор дээшилж үнэлэгдсэн. 2025 онд Баянгол дүүргийн ЗДТГ болон Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын БОУ харьцангуй өндөр өссөн бол Багахангай, Баянзүрх, Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын үнэлгээ буурсан байна.

Хүснэгт 9. Дүүргүүдийн БОУ, 2024, 2025 оныг харьцуулсан байдлаар

№	Байгууллагын нэр	2024 оны эрэмбэ	2025 оны эрэмбэ	2024	2025	Өөрчлөлт
1	Баянгол дүүргийн ЗДТГ	8	1	62.0	88.8	26.8↑
2	Налайх дүүргийн ЗДТГ	5	2	68.6	79.9	11.3↑
3	Хан-Уул дүүргийн ЗДТГ	6	3	78.2	76.3	1.9↓
4	Багануур дүүргийн ЗДТГ	4	4	71.5	75.2	3.7↑
5	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	9	5	67.6	74.9	7.3↑
6	Баянзүрх дүүргийн ЗДТГ	3	6	73.9	71.2	2.7↓
7	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	1	7	49.8	68.4	18.5↑
8	Багахангай дүүргийн ЗДТГ	7	8	66.3	65.1	1.3↓
9	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	2	9	52.4	53.7	1.3↑
	Дүүргүүдийн ЗДТГ-ын БОУ			65.6	72.6	7.0↑

Эх үүсвэр: Судалгааны баг

Дүүргүүдийн БОУ өсөж үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Тухайлбал, 2024 онтой харьцуулахад дүүргүүдийн авлигын талаарх төсөөлөл (11.1↑) оноогоор, авлигыг хянах механизм (3.0↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (6.3↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (7.6↑) оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ.

Баянгол дүүргийн ЗДТГ-ын БОУ 2025 онд бусад дүүргүүдтэй харьцуулахад хамгийн их оноогоор нэмэгдэхэд авлигын талаарх төсөөлөл 2024 онтой харьцуулахад (27.1↑) оноогоор, авлигыг хянах механизм (31.4↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (26.7↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (22.0↑) оноогоор нэмэгдсэн нь нөлөөлсөн.

Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын БОУ нь хамгийн бага оноогоор үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөлөл 2024 онтой харьцуулахад (12.2↑) оноогоор, авлигыг хянах механизм (3.4↑) оноогоор өссөн боловч авлигын бодит тохиолдол (2.0↓) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх механизм (8.3↓) оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ.


2.3 Бодлогод оролцогчдын үнэлгээний дэд үзүүлэлтийн үр дүн

БОУ-ний дэд үзүүлэлтүүд болох авлигын талаарх төсөөллийн индекс, авлигыг хянах механизм, авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүслийн индексүүдийн талаар дэлгэрэнгүй бичив.

Бодлогод оролцогч, шинжээчдийн судалгааны үнэлгээгээр 2025 авлигын талаарх төсөөлөл 76.5 оноотой болж, 2024 онтой харьцуулахад (7.9↑) оноогоор, авлигыг хянах механизм 52.0 оноотой болж, өмнөх онтой харьцуулахад (2.2↑) оноогоор, авлигын бодит тохиолдол 93.8 оноотой болж, өмнөх оноос (3.9↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 65.0 оноотой болж, өмнөх оноос (5.2↑) оноогоор тус тус өсөж үнэлэгджээ.

БОУ-ний үндсэн үзүүлэлтүүд болох авлигын талаарх төсөөлөл, авлигыг хянах механизм, авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл нь өөр хоорондоо харилцан уялдаатай байна. Өөрөөр хэлбэл, аль нэг үзүүлэлт өсөж байхад нөгөө үзүүлэлт буурах боломжгүй юм.

Зураг 5. БОУ, дэд үзүүлэлтээр, оноор




Эх үүсвэр: Судалгааны баг

Авлигын талаарх төсөөллийн үнэлгээ 2021 оноос хойш өсөж байсан ч 2024 онд буурч, 2025 онд эргээд өссөн байна. Харин авлигыг хянах механизмын үнэлгээ 2023 онд өсөж, 2025 онд дахин өсөх хандлага ажиглагдав.

Авлигын бодит тохиолдлын үзүүлэлтийн хувьд бусад үзүүлэлттэй харьцуулахад харьцангуй өндөр бөгөөд 2024 онд буурч, 2025 оноос дахин өссөн байна. Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад харьцангуй хэлбэлзэл багатай.

Зураг 6. БОУ-ний дэд үзүүлэлт, байгууллагын төрлөөр, 2025 он



Эх үүсвэр: Судалгааны баг

Яамдын авлигын талаарх төсөөллийн дундаж үнэлгээ нь улсын дунджаас (2.4↓) оноогоор доогуур, агентлагуудын үнэлгээ нь дунджаас (3.5↑) оноогоор дээгүүр, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ дунджаас (2.7↓) оноогоор доогуур, дүүргүүдийн ЗДТГ-ын үнэлгээ дунджаас (1.5↑) оноогоор дээгүүр байна.

Авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд, яамдын үнэлгээ дунджаас (0.8↓) оноогоор доогуур, агентлагуудын авлигын талаарх төсөөллийн үнэлгээ нь дунджаас (3.5↑) оноогоор дээгүүр, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ дунджаас (2.2↓) оноогоор доогуур, дүүргүүдийн ЗДТГ-ын үнэлгээ дунджаас (0.4↓) оноогоор доогуур байна.

Авлигын бодит тохиолдол үзүүлэлтийн хувьд, яамдын үнэлгээ дунджаас (1.8↑) оноогоор дээгүүр, агентлагуудын авлигын талаарх төсөөллийн үнэлгээ нь дунджаас (0.2↑) оноогоор дээгүүр, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ дунджаас (2.4↓) оноогоор доогуур, дүүргүүдийн ЗДТГ-ын үнэлгээ дунджаас (0.5↑) оноогоор дээгүүр байна.

Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл үзүүлэлтийн хувьд, яамдын үнэлгээ дунджаас (0.1↑) оноогоор дээгүүр, агентлагуудын авлигын талаарх төсөөллийн үнэлгээ нь дунджаас (0.7↑) оноогоор дээгүүр, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ дундаж улсын дундажтай адил, дүүргүүдийн ЗДТГ-ын үнэлгээ дунджаас (1.1↑) оноогоор дээгүүр байна.

Яамдын БОУ-ний дэд үзүүлэлтийн 2025 оны үнэлгээг 2024 онтой харьцуулж дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 10. Яамдын БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2024 онтой харьцуулсан байдал

№	Байгууллагын нэр	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл
1	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	27.6↓	16.6↓	22.6↓	30.2↓
2	Барилга хот байгуулалтын яам	11.7↓	22.4↑	0.0	10.0↓
3	Батлан хамгаалах яам	3.5↓	9.0↓	0.0	8.5↓
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	11.7↑	4.1↓	30.4↓	3.1↑
5	Гадаад харилцааны яам	10.4↓	13.0↓	5.3↓	1.8↓
6	Зам, тээвэр хөгжлийн яам	7.1↑	5.1↑	0.0	7.3↓
7	Сангийн яам	16.0↑	13.3↑	2.7↑	2.4↑

8	Соёлын яам	7.1↑	14.8↓	0.0	1.3↓
9	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	27.8↑	7.1↑	48.5↑	18.9↑
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	17.1↑	10.1↓	0.0	0.1↑
11	Хууль зүй, дотоод хэргийн яам	27.4↓	39.3↓	0.0	24.2↓
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	19.0↑	14.0↑	4.9↑	21.8↑
13	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	22.0↓	2.8↓	2.4↓	4.1↑
14	Эдийн засаг хөгжлийн яам	40.6↑	19.9↑	21.8↑	9.0↑
15	Эрүүл мэндийн яам	5.6↓	8.8↑	2.6↓	1.6↓
16	Эрчим хүчний яам	23.3↑	4.1↑	16.1↑	8.9↑
	Дундаж өөрчлөлт, оноогоор	3.8↑	0.9↓	1.9↑	1.0↓

Эх үүсвэр: Судалгааны баг

Яамдын хувьд, авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийг 2024 онтой харьцуулахад (3.8↑) оноогоор дээшилсэн бол авлигыг хянах механизм үзүүлэлт (0.9↓) буурсан. Авлигын бодит тохиолдол (1.9↑) оноогоор өсөж, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (1.0↓) оноогоор буурсан.

Үзүүлэлт тус бүрээр хамгийн их эерэг өөрчлөлттэй байгаа яамдыг авч үзвэл, авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд Эдийн засаг хөгжлийн яам (40.6↑) оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд Барилга хот байгуулалтын яам (22.4↑) оноогоор, авлигын бодит тохиолдлын хувьд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам (48.5↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл үзүүлэлтийн хувьд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (21.8↑) оноогоор тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Агентлагуудын БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлтийг дараах хүснэгтээр харууллаа. Авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийн хувьд, 2025 онд 2024 онтой харьцуулахад агентлагуудын хувьд (7.6↑) оноогоор, авлигыг хянах механизм (2.1↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (1.4↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (4.6↑) оноогоор тус тус өсөж үнэлэгдсэн байна.

Хүснэгт 11. Агентлагуудын БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2024 онтой харьцуулсан байдал

№	Байгууллагын нэр	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл
1	Архивын ерөнхий газар	21.3↑	12.7↑	2.8↓	13.5↑
2	Ашигт малтмал, газрын тосны газар	22.7↑	3.5↑	35.2↑	16.6↑
3	Биеийн тамир, спортын улсын хороо	20.5↓	4.7↓	3.0↓	9.5↓
4	Боловсролын ерөнхий газар	29.9↑	19.4↑	0.0	20.3↑
5	Гаалийн ерөнхий газар	37.7↑	16.0↑	8.6↑	7.5↑
6	Гадаадын иргэн харьяатын газар	1.0↓	17.2↓	13.4↓	0.7↑
7	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	7.3↑	10.0↑	6.7↓	8.6↓
8	Жижиг, дунд үйлдвэрийн газар	39.0↓	3.1↑	0.0	27.0↓
9	Иргэний нисэхийн ерөнхий газар	27.0↑	21.2↑	0.6↓	27.1↑
10	Мал эмнэлгийн ерөнхий газар	3.2↓	6.4↓	3.3↓	26.2↓
11	Нийгмийн даатгалын ерөнхий газар	6.3↑	0.1↑	12.5↓	12.8↑
12	Ойн газар	17.2↑	0.5↑	5.1↑	19.5↑
13	Онцгой байдлын ерөнхий газар	7.8↑	15.0↑	0.0	0.3↑
14	Оюуны өмчийн газар	13.9↑	9.5↑	2.8↑	3.3↑
15	Соёл урлагийн газар	5.0↓	0.5↑	0.5↓	17.8↑
16	Стандарт, хэмжил зүйн газар	16.6↑	4.1↑	0.0	3.7↑

17	Татварын ерөнхий газар	9.8↑	4.0↑	2.9↓	12.7↑
18	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	8.9↑	14.0↑	3.1↑	4.6↑
19	Төрийн худалдан авах ажиллагааны газар	17.1↑	25.0↑	19.4↑	26.1↑
20	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	2.1↑	11.8↓	4.7↓	10.1↓
21	Улсын бүртгэлийн ерөнхий газар	10.9↑	5.6↓	0.0	17.7↑
22	Усны газар	4.2↓	7.9↓	0.0	12.5↑
23	Үндэсний геологийн алба	42.1↑	14.6↑	42.0↑	27.6↑
24	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	8.1↓	4.4↑	3.1↑	10.3↑
25	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	8.2↑	12.9↓	5.7↓	2.7↓
26	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	5.7↑	12.4↑	4.3↓	5.3↑
27	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	6.3↓	0.1↑	0.0	14.3↓
28	Цаг уур, орчны шинжилгээний газар	19.5↑	0.8↑	17.4↑	4.2↓
29	Цагдаагийн ерөнхий газар	9.3↑	2.5↑	6.4↓	6.1↑
30	Монополын эсрэг газар	8.4↑	4.6↓	12.1↑	5.6↓
31	Шүүх шинжилгээний ерөнхий газар	28.0↓	19.3↓	32.2↓	18.6↓
32	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	2.4↑	11.6↓	2.5↑	7.2↓
33	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	11.5↑	4.4↓	17.6↓	14.7↑
34	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	10.2↑	15.5↓	12.9↑	11.1↑
Дундаж өөрчлөлт, оноогоор		7.6↑	2.1↑	1.4↑	4.6↑

Эх үүсвэр: Судалгааны баг

Үзүүлэлт тус бүрээр хамгийн их эерэг өөрчлөлттэй байгаа агентлагуудыг авч үзвэл, авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд Үндэсний геологийн алба (42.1↑) оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд Төрийн худалдан авах ажиллагааны газрын үзүүлэлт (25.0↑) оноогоор, авлигын бодит тохиолдол Үндэсний геологийн албын үзүүлэлт (42.0↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл “Үндэсний геологийн албын үзүүлэлт (27.6↑) оноогоор тус тус 2024 онтой харьцуулахад өсөж үнэлэгджээ.

Авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд Жижиг, дунд үйлдвэрийн газар (39.0↓) оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд, Шүүх шинжилгээний ерөнхий газар (19.3↓) оноогоор, авлигын бодит тохиолдлын хувьд, Шүүх шинжилгээний ерөнхий газар (32.2↓) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүслийн хувьд, Жижиг, дунд үйлдвэрийн газар (27.0↓) оноогоор тус тус өмнөх оноос буурч үнэлэгджээ.

Аймаг, нийслэлийн БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлтийг 2024 онтой харьцуулахад авлигын талаарх төсөөлөл үзүүлэлт (9.9↑) оноогоор, авлигыг хянах механизм (4.2↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (8.1↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (9.4↑) оноогоор тус тус өсөж үнэлэгджээ.

Хүснэгт 12. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2024 онтой харьцуулсан байдал

№	Байгууллагын нэр	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл
1	Архангай аймгийн ЗДТГ	8.3↓	24.2↓	31.5↓	5.6↓
2	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	14.1↓	1.2↑	15.5↓	12.1↑
3	Баянхонгор аймгийн ЗДТГ	27.8↑	4.7↑	6.3↑	36.2↑
4	Булган аймгийн ЗДТГ	2.1↓	11.4↓	7.6↑	4.2↓

5	Говь-Алтай аймгийн ЗДТГ	27.9↑	13.4↑	18.2↑	25.0↑
6	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	39.2↑	17.3↑	62.5↑	23.1↑
7	Дархан-Уул аймгийн ЗДТГ	5.3↑	0.6↓	19.9↑	3.5↓
8	Дорноговь аймгийн ЗДТГ	5.5↑	7.4↑	3.8↑	4.2↓
9	Дорнод аймгийн ЗДТГ	2.3↑	0.6↓	0.9↑	11.0↑
10	Дундговь аймгийн ЗДТГ	11.4↑	12.9↑	3.8↓	10.6↑
11	Завхан аймгийн ЗДТГ	20.9↑	0.4↑	33.6↑	7.9↑
12	Орхон аймгийн ЗДТГ	4.9↓	0.3↑	10.7↑	7.3↑
13	Өвөрхангай аймгийн ЗДТГ	3.7↑	4.6↓	3.8↓	1.1↑
14	Өмнөговь аймгийн ЗДТГ	5.1↑	8.9↓	0.0	10.6↑
15	Сүхбаатар аймгийн ЗДТГ	33.3↑	19.3↑	40.3↑	29.7↑
16	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	24.3↑	11.8↑	15.4↑	18.2↑
17	Төв аймгийн ЗДТГ	5.2↓	6.2↑	0.0	2.9↓
18	Увс аймгийн ЗДТГ	4.7↑	13.5↑	0.0	14.2↑
19	Ховд аймгийн ЗДТГ	12.2↑	6.6↓	2.8↑	2.1↑
20	Хөвсгөл аймгийн ЗДТГ	24.2↑	35.9↑	3.3↑	0.5↓
21	Хэнтий аймгийн ЗДТГ	13.9↑	3.4↑	6.6↑	17.4↑
22	Нийслэлийн ЗДТГ	8.8↓	1.4↑	0.0	1.9↑
Дундаж өөрчлөлт, оноогоор		9.9↑	4.2↑	8.1↑	9.4↑

Эх үүсвэр: Судалгааны баг

Үзүүлэлт тус бүрээр хамгийн их эерэг өөрчлөлттэй байгаа аймаг, нийслэлийн ЗДТГ-ыг авч үзвэл, авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд “Говьсүмбэр аймгийн ЗДТГ (39.2↑) оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд Хөвсгөл аймгийн ЗДТГ (39.9↑) оноогоор, авлигын бодит тохиолдол Говьсүмбэр аймгийн ЗДТГ (62.5↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл Баянхонгор аймгийн ЗДТГ (36.2↑) оноогоор өмнөх оноос өсөж үнэлэгджээ.

Үзүүлэлт тус бүрээр хамгийн их сөрөг өөрчлөлттэй аймаг, нийслэлийн ЗДТГ-ыг авч үзвэл, авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд Баян-Өлгий аймгийн ЗДТГ (14.1↓) оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд Архангай аймгийн ЗДТГ (24.2↓) оноогоор, авлигын бодит тохиолдлын хувьд Архангай аймгийн ЗДТГ (31.5↓) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүслийн хувьд Архангай аймгийн ЗДТГ (5.6↓) оноогоор өмнөх оноос буурч үнэлэгджээ.

Дүүргүүдийн БОУ-ний дэд үзүүлэлтийг 2024 онтой харьцуулсан өөрчлөлтөөс харахад, авлигын талаарх төсөөлөл (11.1↑) оноогоор, авлигыг хянах механизм (3.0↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (6.3↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (7.6↑) оноогоор тус тус өссөн байна.

Хүснэгт 13. Дүүргүүдийн БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2024 онтой харьцуулсан байдал

№	Байгууллагын нэр	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл
1	Багануур дүүргийн ЗДТГ	5.8↑	5.8↓	0.0	15.0↑
2	Багахангай дүүргийн ЗДТГ	38.6↑	35.5↓	0.0	8.1↓
3	Баянгол дүүргийн ЗДТГ	27.1↑	31.3↑	22.0↑	26.7↑
4	Баянзүрх дүүргийн ЗДТГ	1.7↓	2.9↓	7.1↓	1.1↑
5	Налайх дүүргийн ЗДТГ	11.4↑	16.5↑	0.0	17.4↑
6	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	12.2↑	3.4↑	2.0↓	8.3)
7	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	10.3↑	1.5↑	6.7↑	10.7↑

8	Хан-Уул дүүргийн ЗДТГ	11.8↓	1.9↑	3.3↑	1.2↓
9	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	8.0↑	16.9↑	33.9↑	15.4↑
	Дундаж өөрчлөлт, оноогоор	11.1↑	3.0↑	6.3↑	7.6↑

Эх үүсвэр: Судалгааны баг

Дэд үзүүлэлт тус бүрээр хамгийн их эерэг өөрчлөлттэй дүүргийн ЗДТГ-ыг авч үзвэл, авлигын талаарх төсөөлөл Багахангай дүүргийн ЗДТГ (38.6↑) оноогоор өссөн бол, авлигыг хянах механизм Баянгол дүүргийн ЗДТГ (31.3↑) оноогоор өсжээ. Харин авлигын бодит тохиолдол Чингэлтэй дүүргийн ЗДТГ (33.9↑) оноогоор өссөн бол удирдлагын авлигатай тэмцэх хүсэл Баянгол дүүргийн ЗДТГ (26.7↑) оноогоор өсөж үнэлэгджээ.

Дэд үзүүлэлтүүдийг 2024 онтой харьцуулахад хамгийн их сөрөг өөрчлөлттэй дүүргүүдийн ЗДТГ-ыг авч үзвэл, авлигын талаарх төсөөлөл Хан-Уул дүүргийн ЗДТГ (11.8↓) оноогоор, авлигыг хянах механизм Багахангай дүүргийн ЗДТГ (35.5↓) оноогоор, авлигын бодит тохиолдол Баянзүрх дүүргийн ЗДТГ (7.1↓) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ (8.1↓) оноогоор тус тус буурч үнэлэгдсэн.

Хүснэгт 14. БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, байгууллагын төрлөөр, 2024 онтой харьцуулсан байдал (нэгтгэсэн)

Дундаж өөрчлөлт	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл
Яам	3.8↑	0.9↓	1.9↑	1.0↓
Агентлаг	7.6↑	2.1↑	1.4↑	4.6↑
Аймаг, нийслэлийн ЗДТГ	9.9↑	4.2↑	8.1↑	9.4↑
Дүүргүүдийн ЗДТГ	11.1↑	3.0↑	6.3↑	7.6↑

Эх үүсвэр: Судалгааны баг

Дэд үзүүлэлтийн өөрчлөлтийг 2024 онтой харьцуулсан үзүүлэлтээс харахад, БОУ-ээр дүүргүүдийн ЗДТГ-ын хувьд авлигын талаар төсөөллийн шударга байдал хамгийн их өссөн бол авлигыг хянах механизм яамдын хувьд буурсан байна.

Авлигын бодит тохиолдлын үнэлгээ бүх байгууллагуудад өссөн эерэг талтай байна. Харин яамдын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл буурчээ.

2.4. БОУ гүйцэтгэл багатай байгууллагууд

2025 онд хамгийн бага БОУ авсан байгууллагууд болон тус онд өмнөх оноос хамгийн их үнэлгээний бууралттай байгууллагуудын үнэлгээний үзүүлэлтүүдийг тус бүрчлэн задлан шинжлэв.

2.4.1. Хамгийн бага үнэлгээтэй байгууллагууд

БОУ хамгийн бага 5 байгууллагууд нь Шүүх шинжилгээний ерөнхий газар, Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ, Архангай аймгийн ЗДТГ, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам байна. Эдгээр байгууллагын үнэлгээний бууралтад нөлөөлж байгаа хүчин зүйлсийг байгууллага тус бүрээр судлав. (Бусад байгууллагуудын дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу).

1. Шүүх шинжилгээний ерөнхий газар

Шүүх шинжилгээний ерөнхий газар нь 2025 онд БОУ-ээр 67 байр ухарч, 77 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна. Тус байгууллагын БОУ нь 2024 онтой харьцуулахад (24.4↓) оноогоор буурч үнэлэгдэхэд тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл (28.0↓)

оноогоор, авлигыг хянах механизм (19.3↓) оноогоор, авлигын бодит тохиолдол (32.2↓) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (18.6↓) оноогоор тус тус буурсан нь ийнхүү нөлөөлжээ.

Хүснэгт 15. Шүүх шинжилгээний ерөнхий газрын БОУ-ний дэд үзүүлэлт, түүний өөрчлөлт

№	Үзүүлэлт	2024	2025	Өөрчлөлт
	БОУ	78.2	53.7	24.5↓
	Авлигын талаарх төсөөлөл	82.2	54.2	28.0↓
A1	Тухайн байгууллагад авлига хэр түгээмэл байна вэ?	76.6	65.8	10.8↓
A2	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал	83.8	46.1	37.7↓
A3	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал	82.9	61.1	21.8↓
A4	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал	79.7	72.5	7.2↓
A5	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал	85.7	41.3	44.4↓
A6	Албан хаагчид нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал	86.8	56.6	30.2↓
A7	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ хийх ёстой үйлдлийг хийхгүй/хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал	88.9	55.0	33.9↓
A8	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал	72.2	40.8	31.4↓
A9	Албан хаагчид нь албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал	82.8	48.7	34.1↓
	Авлигыг хянах механизмын үзүүлэлт	58.5	39.2	19.3↓
A10	Дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал	47.9	18.4	29.5↓
A11	Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал	56.3	47.5	8.8↓
A12	Шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал	71.4	51.6	19.8↓
	Авлигын бодит тохиолдол	97.1	64.9	32.2↓
A13	Та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн байдал	100.0	66.7	33.3↓
A14	Албан хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө, болон бусад үнэ бүхий зүйлс авсан байдал	94.1	63.2	30.9↓
	Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл	75.0	56.4	18.6↓
A15	Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл	76.6	56.3	20.3↓
A16	Дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл	73.5	56.6	16.9↓

Эх үүсвэр: Судалгааны баг

Шүүх шинжилгээний ерөнхий газрын авлигын талаарх төсөөлөл буурч үнэлэгдэхэд албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал (44.4↓) оноогоор буюу бараг 2 дахин буурсан нь нөлөөлжээ. Судалгаанд оролцсон оролцогч, шинжээчдийн 55.0 хувь нь түгээмэл, ихээхэн түгээмэл гэж хариулсан нь хамгийн ихээр нөлөөлсөн байна. Мөн албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 2024 онтой харьцуулахад (37.7↓) оноогоор буурч, “Огт байхгүй” гэсэн хариулт сонгогдоогүй нь үүнд нөлөөлжээ.

Албан хаагчид нь албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал (34.1↓) оноогоор, албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ хийх ёстой үйлдлийг хийхгүй/хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал (33.9↓) оноогоор, албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал (31.4↓) оноогоор, албан хаагчид албан үүрэгтэй нь

холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө, болон бусад үнэ бүхий зүйлс авсан байдал (30.9↓) оноогоор, албан хаагчид нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал (30.2↓) оноогоор буурсан байна.

Судалгаанд оролцогч бодлогын шинжээчдийн 41.8 хувь нь авлига хэр түгээмэл эсэхэд дунд ба дундаас дээш үнэлгээг өгсөн бол 40.0 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчид, албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйлс өгсөн талаар, мөн 35.0 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд алба хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө болон бусад үнэ бүхий зүйлс авсан талаар сонссон гэж хариулсан нь үнэлгээг доогуур үнэлэгдэхэд нөлөөлжээ. Тус байгууллагын удирдлага болон дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийн үр дүнг судалгаанд оролцогчдын 65.0 хувь “огт үр дүнгүй”, “үр дүнгүй”, “заримдаа” гэсэн хариултыг сонгосон.

Шүүх шинжилгээний ерөнхий газар БОУ-ээр бараг жил болгон сүүлийн байруудад орж байгаа тул тус байгууллагаас авлигатай тэмцэх талаар хийж буй ажлуудыг судалж үзлээ. Ингэхэд Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө (Шүүх шинжилгээний ерөнхий газар, 2025) -нд нийт 12 ажил төлөвлөсөн боловч ихэнх нь олон нийт болон албан хаагчдыг соён гэгээрүүлэхэд чиглэгджээ. Харин бодит кейсийг таслан зогсоох, албан хаагчдын хариуцлага, ёс зүйг баримтлахад чиглэсэн бодит ажлуудыг төлөвлөгөөгүй гэж үзэж байна.

2. Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ

Хэдийгээр Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын БОУ үнэлгээгээр сүүлийн 4 байранд буюу 78 дугаарт орж байгаа ч 2025 онд БОУ нь (1.3↑) оноогоор өсөж, ерөнхий үнэлгээ нь 53.7 болжээ.

Хүснэгт 16. Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ -ын БОУ, түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Үзүүлэлт	2024	2025	Өөрчлөлт
	БОУ	52.4	53.7	1.3↑
	Авлигын талаарх төсөөлөл	46.0	58.2	12.2↑
A1	Тухайн байгууллагад авлига хэр түгээмэл байна вэ?	26.8	62.5	35.7↑
A2	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал	42.9	55.6	12.7↑
A3	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал	50.0	56.3	6.3↑
A4	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал	44.6	62.5	17.9↑
A5	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал	50.0	61.1	11.1↑
A6	Албан хаагчид нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал	46.4	56.8	10.4↑
A7	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ хийх ёстой үйлдлийг хийхгүй/хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал	52.1	52.8	0.7↑
A8	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал	45.5	62.5	17↑
A9	Албан хаагчид нь албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал	55.8	54.2	1.6↓
	Авлигыг хянах механизмын үзүүлэлт	42.7	46.1	3.4↑
A10	Дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал	39.6	45.8	6.2↑
A11	Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал	40.4	50.0	9.6↑
A12	Шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал	48.2	42.5	5.7↓

Авлигын бодит тохиолдол		70.7	68.8	1.9↓
A13	Та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн байдал	63.6	62.5	1.1↓
A14	Албан хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө, болон бусад үнэ бүхий зүйлс авсан байдал	77.8	75.0	2.8↓
Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл		50.0	41.7	8.3↓
A15	Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл	50.0	41.7	8.3↓
A16	Дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл	50.0	41.7	8.3↓

Эх үүсвэр: Судалгааны баг

Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын БОҮ үнэлгээний дэд үзүүлэлтүүд тус бүрийн оноог харвал, 60.0 оноос дээш оноотой 6 үзүүлэлт байна. Бүх үзүүлэлтүүд нэлэнхийдээ доогуур үнэлгээтэй буюу 60-аас доош, 40-ээс дээш оноо авсан нь анхаарал татахуйц юм.

Судалгаанд оролцогчдын 73.3 хувь нь удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийг дунд ба дундаас доош, дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийг дунд ба дундаас доош хэмээн үнэлжээ.

Сонгинохайрхан дүүргийн тогтвортой хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичиг (Нийслэлийн ЗДТГ, 2020)-т “Төрийн байгууллагуудыг ил тод, хариуцлагатай сайн засаглалтай болгон ажилтнуудыг чадавхжуулж, тогтвортой хөгжлийн төлөөх иргэдийн оролцоотой түншлэлийг бэхжүүлнэ” хэмээн тусгагдсанаас гадна авлигын эсрэг ажлуудыг төлөвлөсөн байгаа хэдий ч хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

3. Архангай аймгийн ЗДТГ

Архангай аймгийн ЗДТГ -ын БОҮ нь 2025 онд 51.2 оноотой болж, 2024 оноос (17.4↓) оноогоор буурч, 79-р байрт эрэмбэлэгдсэн. Тус байгууллагын БОҮ буурч үнэлэгдэхэд авлигын бодит тохиолдлын үнэлгээ хамгийн ихээр буурсан нь нөлөөлжээ. Өөрөөр хэлбэл, өмнөх онд судалгаанд оролцогчид 100 хувь энэ талаар сонсоогүй байсан бол энэ жил судалгаанд оролцогчдын 50 гаруй хувь нь гэр бүлийн гишүүд болон, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн талаар сонсож байсан бол, мөн бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө, болон бусад үнэ бүхий зүйлс авсан талаар сонссон гэж хариулсан нь ийнхүү нөлөөлсөн байна.

Хүснэгт 17. Архангай аймгийн ЗДТГ-ын БОҮ, түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Үзүүлэлт	2024	2025	Өөрчлөлт
	БОҮ	68.6	51.2	17.4↓
	Авлигын талаарх төсөөлөл	62.0	53.7	8.3↓
A1	Тухайн байгууллагад авлига хэр түгээмэл байна вэ?	55.0	41.7	13.3↓
A2	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал	68.3	65.0	3.3↓
A3	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал	65.0	51.7	13.3↓
A4	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал	63.6	53.3	10.3↓
A5	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал	61.1	60.0	1.1↓
A6	Албан хаагчид нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал	70.8	56.7	14.1↓

№	Үзүүлэлт	2024	2025	Өөрчлөлт
A7	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ хийх ёстой үйлдлийг хийхгүй/хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал	68.8	57.1	11.7↓
A8	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал	30.0	35.0	5.0↑
A9	Албан хаагчид нь албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал	75.0	62.5	12.5↓
Авлигыг хянах механизмын үзүүлэлт		55.8	31.6	24.2↓
A10	Дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал	57.5	21.2	36.3↓
A11	Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал	47.5	30.8	16.7↓
A12	Шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал	62.5	42.9	19.6↓
Авлигын бодит тохиолдол		100.0	68.5	31.5↓
A13	Та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн байдал	100.0	73.3	26.7↓
A14	Албан хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө, болон бусад үнэ бүхий зүйлс авсан байдал	100.0	63.6	36.4↓
Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл		56.8	51.3	5.5↓
A15	Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл	60.0	42.5	17.5↓
A16	Дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл	53.6	60.0	6.4↑

Эх үүсвэр: Судалгааны баг

Архангай аймгийн ЗДТГ-ын БОУ-нд “албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал”, “дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл” гэсэн хоёр үзүүлэлтэд харгалзах оноо өмнөх жилээс өссөн бол бусад бүх үзүүлэлтүүд буурсан байна.

“Авлига хэр түгээмэл байна гэж та үзэж байна вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 66.7 хувь нь дунд ба түгээмэл, ихээхэн түгээмэл хариултыг өгчээ. “Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал” – д судалгаанд оролцогчдын 66.7 хувь нь дунд, огт ил тод биш, ил тод биш хариултыг өгснөөс харахад авлигын тохиолдол илэрснийг илтгэнэ. “Дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал”-ыг үнэлүүлэхэд, судалгаанд оролцогчдын 73.3 хувь нь нийлэхгүй хариултыг өгсөн. Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдалд мөн 73.3 хувь нь санал нийлэхгүй гэжээ.

Төрийн албаны ёс зүйн зөрчлөөр Архангай аймаг эхний 3 дугаарт буюу ёс зүйн зөрчил ихтэй аймгуудад багтжээ (МУ-ын Ёс зүйн хороо, 2025).

Архангай аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааг судалж, зөвхөн нэг жишээг л дурдахад, “2024 оны үйл ажиллагаа болон санхүү, төсвийн гүйцэтгэлд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулаагүй байна” гэсэн дүгнэлтийг Архангай аймаг дахь төрийн аудитын газар (Архангай аймаг дахь төрийн аудитын газар, 2025) -аас хийсэн байна. Иймд Архангай аймгийн ЗДТГ нь дотоод хяналт шалгалтыг чанаржуулах, авлигатай тэмцэхэд идэвх, санаачилгатай ажиллах шаардлагатай байна.

4. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам:

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны БОУ нь 2025 онд 46.3 оноотой болж, 2024 оноос (24.2↓) оноогоор буурсан ба 80 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны бүх үзүүлэлтүүд өмнөх оноос буурсан байгаа бөгөөд хамгийн ихээр буурсан нь “Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал”, “Албан хаагчид нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал”, “Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ хийх ёстой үйлдлийг хийхгүй/хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал”, “Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл”, “Дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл”, “авлига хэр түгээмэл эсэх” гэсэн дэд шалгуур үзүүлэлтүүд байна.

Хүснэгт 18. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны БОУ, түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Үзүүлэлт	2024	2025	Өөрчлөлт
	БОУ	70.5	46.3	24.2↓
	Авлигын талаарх төсөөлөл	74.4	46.8	27.6↓
A1	Тухайн байгууллагад авлига хэр түгээмэл байна вэ?	71.1	39.5	31.6↓
A2	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал	77.4	42.6	34.8↓
A3	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал	79.8	52.8	27.0↓
A4	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал	73.7	42.2	31.5↓
A5	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал	70.8	55.3	15.5↓
A6	Албан хаагчид нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал	80.7	45.6	35.1↓
A7	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ хийх ёстой үйлдлийг хийхгүй/хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал	80.0	47.1	32.9↓
A8	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал	62.5	50.0	12.5↓
A9	Албан хаагчид нь албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал	73.8	46.4	27.4↓
	Авлигыг хянах механизмын үзүүлэлт	53.4	36.8	16.6↓
A10	Дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал	43.8	33.9	9.9↓
A11	Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал	55.4	37.5	17.9↓
A12	Шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал	61.1	39.1	22.0↓
	Авлигын бодит тохиолдол	88.0	65.4	22.6↓
A13	Та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн байдал	90.9	69.2	21.7↓
A14	Албан хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө, болон бусад үнэ бүхий зүйлс авсан байдал	85.0	61.5	23.5↓
	Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл	66.2	36.0	30.2↓
A15	Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл	73.6	36.7	36.9↓
A16	Дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл	58.8	35.3	23.5↓

Эх үүсвэр: Судалгааны баг

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд авлигын нөлөө түгээмэл байгаа эсэхэд судалгаанд оролцогчдын 36.0 хувь нь түгээмэл гэж хариулсан нь уг асуултад харгалзах үнэлгээ (31.6↓) оноогоор буурах шалтгаан болжээ. Судалгаанд оролцогчдын 32.0 хувь нь албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг, 28.0 хувь нь албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад хууль бусаар давуу байдал олгодог, 32.0 хувь нь албан хаагчид нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг, 28.0 хувь нь “албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ хийх ёстой үйлдлийг хийхгүй/хийхгүй ёстой үйлдлийг хийдэг” хэмээн хариулсан.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар гэхэд л 248 санал, гомдол (Байгаль орчин, 2025) ирүүлсэн нь тус салбарт болон байгууллагад шийдвэрлэх олон асуудал байгааг илтгэнэ.

5. Боловсрол шинжлэх ухааны яам:

Боловсрол шинжлэх ухааны яамны БОУ нь 2025 онд 44.2 оноотой болж, 2024 оноос (5.0↓) оноогоор буурсан ба 81 дүгээрт эрэмбэлэгджээ.

Боловсрол шинжлэх ухааны яамны өмнөх жилийн БОУ нь 49.2 оноотой байсан боловч энэ жил дахин буурсан байна. Дэд шалгуур үзүүлэлтүүдийн хувьд зарим үзүүлэлтүүдийн оноо дээшилсэн мэт харагдавч 4-5 үзүүлэлт л 50.0 оноо ба түүнээс дээш, харин бусад бүх үзүүлэлтийн оноо 50.0 оноос ч доогуур үнэлгээтэй байгааг анхаарах хэрэгтэй.

Хүснэгт 19. Боловсрол шинжлэх ухааны яамны БОУ, түүний дэд үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	2024	2025	Өөрчлөлт
	БОУ	49.2	44.2	5.0↓
	Авлигын талаарх төсөөлөл	35.3	47.0	11.7↑
A1	Тухайн байгууллагад авлига хэр түгээмэл байна вэ?	34.4	44.1	9.7↑
A2	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал	42.5	50.0	7.5↑
A3	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал	31.9	51.5	19.6↑
A4	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал	31.9	40.0	8.1↑
A5	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал	31.9	46.9	15.0↑
A6	Албан хаагчид нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал	31.9	46.9	15.0↑
A7	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ хийх ёстой үйлдлийг хийхгүй/хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал	38.9	46.9	8.0↑
A8	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал	35.5	51.5	16.0↑
A9	Албан хаагчид нь албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал	38.9	45.0	6.1↑
	Авлигыг хянах механизмын үзүүлэлт	34.1	30.0	4.1↓
A10	Дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал	39.3	23.5	15.8↓
A11	Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал	29.5	23.3	6.2↓
A12	Шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал	33.3	43.1	9.8↑
	Авлигын бодит тохиолдол	92.3	61.9	30.4↓
A13	Та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн байдал	100.0	66.7	33.3↓
A14	Албан хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө, болон бусад үнэ бүхий зүйлс авсан байдал	84.6	57.1	27.5↓

№	Үзүүлэлт	2024	2025	Өөрчлөлт
Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл		35.0	38.1	3.1↑
A15	Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл	35.3	36.1	0.8↑
A16	Дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл	34.6	40.0	5.4↑

Эх үүсвэр: Судалгааны баг

Боловсрол шинжлэх ухааны яамны авлигыг хянах механизмын үзүүлэлтүүд болох дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал нь 100 онооноос 30 оноонд ч хүрэхгүй байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын 84.0 хувь хангалтгүй үнэлгээг өгсөн.

Авлигын талаарх төсөөллийн үнэлгээ өмнөх жилээс өссөн мэт харагдавч дэд шалгуур бүрд өгсөн үнэлгээ нь 50 оноо ба түүнээс доош байна. Тухайлбал: Судалгаанд оролцогчдын 52.0 хувь нь “албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал” гэсэн асуултад түгээмэл гэсэн хариултуудыг өгсөн.

Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэлд өгсөн үнэлгээ нь өмнөх жилийнхтэй бараг адилхан байгаа нь тус яамны удирдлага, ажилтнууд авлигыг бууруулах ажил хийгээгүй эсвэл хийсэн ажлууд нь үр дүн муутай байсныг илтгэнэ.

Хамгийн бага оноотойгоор үнэлэгдсэн Боловсрол, шинжлэх ухааны яаманд иргэд, байгууллагуудаас ч өөрсдөд нь хаягласан санал, гомдол багагүй ирдэг нь хоёрдогч эх үүсвэрийн мэдээнээс тодорхой байна. Тухайлбал: БШУЯ-ны 2025 оны 1 дүгээр сарын сарын үйл ажиллагааны тайлан мэдээ (БШУЯ, 2025) -нд дурдсанаар 891 санал, гомдлыг тус яам хүлээж авчээ.

Тус яамны БОУ хамгийн бага байгаа нь авлигын эсрэг зохион байгуулсан ажил, хийхээр төлөвлөж буй ажлын санал, санаачлаг хангалтгүй, удирдлагын болон албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээ сул, авлигын бодит тохиолдлын талаар цахим орчинд мэдээлэл гарсан зэргээс гадна олон нийтийн сүлжээн дэх сөрөг хандалтууд ч бас нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй. Тухайлбал: ЭЕШ-ыг зохион байгуулалтыг алдаатай хийсэн (УИХ-ын гишүүн Н.Батсүмбэрэл, 2025), 120 сургуульд 1.2 тэрбум төгрөг юунд зарцуулагдав? (Б.Адьяатөр, 2025) гэх мэт асуудлууд.


БҮЛЭГ 3: МОНГОЛ УЛС ДАХЬ АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Монгол Улс дахь авлигын шалтгаан, нөхцөл, авлига хамгийн их тархсан институцийн талаар болон ирэх 2 жилийн авлигын нөхцөл байдлын төсөөлөл, АТГ-ын үйл ажиллагааны үнэлгээний үр дүнгүүдийг судлав.

3.1 Монгол Улс дахь авлигын өнөөгийн нөхцөл байдал

Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээний бодлогод оролцогч, шинжээчдээс авах судалгааны нэг хэсэг нь Монгол Улс дахь авлигын өнөөгийн нөхцөл байдлыг тодруулах асуулт байв.

Зураг 7. Монгол улс дахь авлигын өнөөгийн нөхцөл байдал, хувиар



Эх үүсвэр: Судалгааны баг

Судалгаанд оролцсон бодлогод оролцогч, шинжээчдийн 56.7 хувь нь буюу талаас илүү хувь нь “ихээхэн түгээмэл” ба “түгээмэл” гэж хариулсан нь Монгол Улсад авлига түгээмэл үзэгдэл болсныг батална. Судалгаанд оролцогчдын ердөө 0.8 хувь нь л “Монгол Улсад авлига байхгүй” хэмээн хариулсан. Харин “мэдэхгүй” гэсэн хариултын тоо өмнөх жилүүдээс үл ялиг өсөж 10.1 хувьд хүрсэн нь судалгаанд оролцогчид бодит кейс мэдэхгүй байсан учраас таамгаар хариулахыг хүсээгүй байж болох талтай.

3.2 Монгол Улс дахь авлига хамгийн их тархсан институц

Судалгаанд оролцогч шинжээчдээр Монгол Улсад авлига хамгийн их тархсан институцийг нэрлүүлж эрэмбэлүүлээ.

Хүснэгт 20. Монгол улсад авлига хамгийн их тархсан институц, хариултад эзлэх хувиар

№	Институцийн төрөл	2025	2025 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ
1	Шүүх	11.1%	I	I
2	Газрын алба	10.4%	II	II
3	Улс төрийн нам	9.9%	III	IV
4	Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	9.2%	IV	VII
5	Гаалийн байгууллага	9.0%	V	V
6	Эрүүл мэндийн байгууллага	8.8%	VI	III
7	Цагдаагийн байгууллага	7.2%	VII	VIII
8	Боловсролын байгууллага	6.7%	VIII	VI
9	Нутгийн захиргааны байгууллага	6.7%	IX	IX
10	Прокурорын байгууллага	6.3%	X	X

11	Хэвлэл мэдээллийн байгууллага	6.3%	XI	XII
12	Татварын байгууллага	5.3%	XII	XI
13	Төрийн бус байгууллага	1.7%	XIII	XIII
14	Хувийн хэвшил	1.5%	XIV	XIV


Эх үүсвэр: Судалгааны баг

Монгол улсад авлига хамгийн их тархсан 5 институцээр “Шүүхийн байгууллага”, “Газрын алба”, “Улс төрийн нам”, “Төрийн захиргааны яам, агентлаг”, “Гаалийн байгууллага” байна. Уг үзүүлэлтийг 2024 онтой харьцуулбал, “Эрүүл мэндийн байгууллага”-ын үзүүлэлт өмнөх оноос гурван байраар сайжирч авлига хамгийн их тархсан 5 институцэд багтаагүй ч эхний 6 байгууллагад байна. Өнгөрсөн жил 7 дугаарт эрэмбэлэгдэж байсан “Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг” нь 2025 онд эхний 4 дүгээрт эрэмбэлэгджээ.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын Дээд шүүх хамтран “Хууль хэрэглээний нэгдмэл байдал, эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тулгамдсан асуудал” сэдэвт хэлэлцүүлгийг 2024 онд зохион байгуулсан. Энэ хэлэлцүүлгээс “Иргэдийн шүүх засаглалд итгэх итгэл жилээс жилд буурч буйн учир шалтгааныг шүүгчдийн ёс зүй, хараат бус байдалтай холбон тайлбарлах болсон ч боловсруулагдан батлагдаж буй хуулиудын чадамж нь хэрэглээ болоод шийдвэр гүйцэтгэлийн явцад олон арван бэрхшээл дагуулж байна” (О.Алтангэрэл, 2024) хэмээн дүгнэжээ. Эндээс, Шүүхийн байгууллагууд өөрсдөө ч бас асуудлаа тодорхойлж авлигыг бууруулахаар зорин ажиллаж байна гэж үзэж болно.

Бодлогод оролцогч, шинжээчдээр авлигыг бууруулах, албан хаагчдыг авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд хийх шаардлагатай зүйлсийн талаар асууж, хариултуудыг дараах зургаар харуулав.

Зураг 8. Бодлогод оролцогч, шинжээчдийн хувьд авлигыг бууруулах, албан хаагчдыг авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд хийх шаардлагатай зүйлс, хариултад эзлэх хувиар



Эх үүсвэр: Судалгааны баг


Судалгааны дүнгээс харахад, авлигаас урьдчилан сэргийлэх, бууруулахын тулд дараах ажлуудыг чухалчилж анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- Иргэдийн боловсролыг сайжруулах, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх– 28.2 хувь
- Хувь хүний хандлагыг өөрчлөх, ёс зүйтэй иргэдийг бий болгох– 15.9 хувь
- Шударга бус байдлыг бууруулах– 8.5 хувь
- Ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, амьжиргааны түвшин сайжруулах– 7.3 хувь
- Хууль дүрмийг баримтлах, хүн бүрд тэгш үйлчилдэг байх– 6.5 хувь.

3.3. Монгол Улс дахь авлигын үндсэн шалтгаан, нөхцөл

Монгол Улс дахь авлигын үндсэн шалтгаан, нөхцөлийг судалгаанд оролцогчдоор нэрлүүлж, нийт хариултад эзлэх хувиар дараах зургаар харуулав.

Зураг 9. Монгол улс дахь авлигын үндсэн шалтгаан, нөхцөл, хариултад эзлэх хувиар



Эх үүсвэр: Судалгааны баг

Бодлогод оролцогч, шинжээчид авлигын шалтгаан, нөхцөлийг дараах эрэмбээр онцоллоо. Үүнд:

- Цалин хөлс бага - 16.8 хувь
- Ажилгүйдэл, ядуурал, амьжиргааны түвшин, үнийн өсөлт - 11.7 хувь
- Хувь хүний хандлага, шунал, ёс зүй - 7.7 хувь

- Хүнд суртал их - 7.1 хувь
- Эрх мэдлээ урвуулан ашиглах, эрх мэдэл төвлөрөл - 5.0 хувь.


Монгол Улсад авлига тархаж байгаа шалтгаануудаас хамгийн их хувь эзэлж байгаа цалин хөлс бага, ядуурал их, амьжиргааны түвшин доогуур байгаа байдал, мөн хувь хүний ёс суртахуун дорой байгаа байдал, мөн хариуцлага тооцдоггүй байдал, хүнд суртал газар авсантай холбон тайлбарласан байна. Эдгээр зүйлс байгаа учраас өнөөдөр Монгол Улсад авлига буурахгүй байна гэж бодлогод оролцогч, шинжээчид үзжээ.

3.4. Монгол Улс дахь авлигын ирээдүйн 2 жилийн төсөөлөл

Олон улсын түвшинд авч үзвэл, 2024 оны байдлаар Монгол Улс авлигын индексээр 180 орноос 114 дүгээр байранд жагсаж, ардчилсан бус засаглалтай орнуудын тоонд багтжээ (Транспэрэнси Интернэшнл Монгол, 2025). Монгол Улс 2017 онд 36 оноо авч 103 дугаар байр, 2018 онд 37 оноо авч 93 дугаар байр, 2019 онд 35 оноо авч 106 дугаар байр, 2020 онд 35 оноо авч 111 дүгээр байр, 2021 онд 35 оноо авч 110 дугаар байр, 2022 онд 33 оноо авч 116 дугаар байр, 2023 онд 33 оноо авч 121 дүгээр байрыг тус тус эзэлж байжээ (Transparency International, 2025).

Ирэх 2 жилд Монгол Улс дахь авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаар асууж өмнөх жилүүдийнхтэй зэрэгцүүлж дараах зургаар харуулав.

Зураг 10. Ирэх 2 жилд Монгол улс дахь авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх төсөөлөл



Эх үүсвэр: Судалгааны баг

Судалгаанд оролцогчдын төсөөллийн судалгаанаас харахад, 38.0 хувь нь өөрчлөгдөхгүй энэ хэвээр байна, 19.4 хувь буурна, 1.8 хувь нь их буурна хэмээн өөдрөг хариултыг өгсөн. Харин судалгаанд оролцогчдын 3.6 хувь “их өснө”, 15.2 хувь нь “өснө” хэмээн хариулсан нь өмнө жилээс бараг зэрэг буурсан үзүүлэлт байна.


Авлигыг бууруулахад улсын хэмжээнд төрийн бүх институциуд, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоо чухал байна. Монгол Улсад бүх салбарт шат шатандаа анхаарч ажиллах шаардлагатай.

3.5 Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үнэлгээ

Авлигатай тэмцэх газраас хийсэн ажлын тайланг жилээр, хагас жилээр нийтийн хүртээл болгож танилцуулдаг. Эдгээр хийгдсэн ажлуудаас зөвхөн сургалтыг нь л 2025 оны эхний хагас жилийн байдлаар судлахад, тайлант хугацаанд 6 удаагийн сургалт (цахим, танхимаар)-д 1697 ЭБАТ, нийтийн албан тушаалтныг 25 удаагийн сургалтад нийт 5496 мэдүүлэг гаргагчийг хамруулсан байна (АТГ, 2025).

Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны талаарх асуултын хариултыг сүүлийн 5 жилийн дүнтэй харьцуулж дараах зургаар харуулав.

Зураг 11. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үнэлгээ, хувиар



Эх үүсвэр: Судалгааны баг

Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 40.9 хувь нь дунд зэрэг, 19.2 хувь нь үр ашигтай, 14.3 хувь нь үр ашиггүй, 7.3 хувь нь огт үр ашиггүй, 2.7 хувь нь ихээхэн үр ашигтай, 15.6 хувь нь мэдэхгүй байна гэж хариулжээ. 2024 онтой харьцуулахад ихээхэн үр ашигтай, үр ашигтай, дунд зэрэг гэсэн хариултууд 0.1-1.2 пунктээр өссөн бол үр ашиггүй, огт үр ашиггүй, мэдэхгүй байна гэсэн хариултууд 0.1-1.3 пунктээр буурсан байна.

АТГ-ын үйл ажиллагааг ганцхан асуултаар үнэлж дүгнэхэд учир дутагдалтай. Гэсэн хэдий ч үйл ажиллагааг нь “дунд зэрэг ба түүнээс дээш” гэж хариулсан хариулт нь 62.8 хувийг эзэлж байгаа нь чамлахаар үзүүлэлт биш юм. Харин “хариулаагүй ба мэдэхгүй” гэсэн оролцогчдын эзлэх хувь 15.6 хувьд хүрснийг анхаарч цаашид олон нийтийн боловсролд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэхийг санал болгож байна.

ДҮГНЭЛТ

Монгол улс 2006 онд Авлигын эсрэг хуулийг баталж, энэхүү хуулийн хүрээнд Авлигатай тэмцэх газар “авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гарган, олон нийтэд мэдээлэх”, мөн төрийн байгууллагуудын шударга байдлыг үнэлж олон нийтэд мэдээлэх үүргийг хүлээдэг.

Шударга байдлын үнэлгээ нь гадаад болон дотоод шударга байдал, бодлогод оролцогчдын үнэлгээнээс бүрддэг бөгөөд 2025 онд төрийн байгууллагуудын шударга байдлын талаар бодлогод оролцогчид, шинжээчдээс авсан судалгааны тайлангийн үр дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг өгч байна. Үүнд:

БОУ нь 2025 онд 71.8 оноо болж, 2024 онтой харьцуулахад (4.8↑) оноогоор дээшилж үнэлэгдсэн бөгөөд авлигын талаарх төсөөлөл (7.9↑) оноогоор, авлигыг хянах механизм (2.2↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (3.9↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (5.1↑) оноогоор тус тус өссөн нь нөлөөлжээ.

Яамдын БОУ нь 71.1 оноо болж (2.6↑) оноогоор, агентлагуудын БОУ нь 73.9 оноо болж (3.9↑) оноогоор, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ нь 70.1 оноо болж (7.9↑) оноогоор, дүүргүүдийн БОУ нь 72.6 болж (7.0↑) дээшилж үнэлэгдлээ. Яамдын БОУ өсөж үнэлэгдэхэд яамдын авлигын талаарх төсөөлөл (7.6↑) оноогоор, авлигыг хянах механизм (2.1↑) оноогоор, авлигын бодит тохиолдол 1.4↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (4.6↑) оноогоор тус тус өссөн нь нөлөөлжээ. Авлигын талаарх төсөөллийн үнэлгээ нь Эдийн засаг, хөгжлийн яам (40.6↑) оноогоор, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам (27.8↑) оноогоор өссөн байв. Харин авлигын бодит тохиолдлын үнэлгээгээр Боловсрол, шинжлэх ухааны яам (30.4↓) оноогоор, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (22.6↓) оноогоор буурсан байгааг анхаарах шаардлагатай нь судалгааны үр дүнгээс тодорхой байна.

Яамдын үнэлгээг нэгтгэн дүгнэвэл, авлигын бодит тохиолдол буюу гэр бүл, найз нөхөд, танил талаас бэлэг өгсөн тохиолдол илэрсэн байдал хамгийн чухал нөлөөтэй байв. Иймд авлигын бодит тохиолдлыг гаргахгүй байхад анхаарах хамгийн чухал байгаагаас гадна “албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах”, “алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ хийх ёстой үйлдлийг хийхгүй/хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал”-ыг хязгаарлахад илүүтэй анхаарах шаардлагатай.

Агентлагуудын БОУ өмнөх оноос (3.9↑) оноогоор өсөж үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөлөл (7.6↑) оноогоор, ажлыг хянах механизм (2.1↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (1.4↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (4.6↑) оноогоор тус тус өсөж үнэлэгдсэн нь нөлөөлсөн. Агентлагуудаас “Төрийн худалдан авах ажиллагааны газар”-ын хувьд 2025 онд БОУ хамгийн ихээр буюу (21.9↑) оноогоор нэмэгдэхэд тухайн байгууллагын авлигыг хянах механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл сайжирсантай холбоотой. Харин Шүүх шинжилгээний ерөнхий газрын хувьд 2025 онд БОУ хамгийн ихээр буурч буюу (24.5↓) оноогоор буурсан. Иймд авлигын талаарх төсөөлөл, авлигын бодит тохиолдлыг хамгийн ихээр бууруулахад анхаарах хэрэгтэй.

Агентлагуудын үнэлгээг нэгтгэн дүгнэвэл, удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл үнэлгээнд нөлөөлөх хамгийн чухал үзүүлэлт байна. Энэ үнэлгээ 1 оноогоор дээшлэхэд БОУ 0.67 оноогоор дээшлэх зүй тогтолтой. Үүний дараа “дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл” чухал нөлөөг үзүүлж байгаа тул ялангуяа, БОУ нь доогуур үнэлэгдсэн агентлагуудын бүх шатны удирдлагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сайжруулах хэрэгтэй. Яамдын нэгэн адилаар, “Алба хаагчид албаны мэдээллийг хувийн зорилгоор

ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал” байсаар байгааг анхаарч ажиллах чухал юм. Аливаа хууль, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт хэрхэн хангагдах нь агентлагийн үйл ажиллагаанаас шууд хамаардаг тул удирдлагууд нь авлигын эсрэг идэвх санаачилгатай ажиллах, таслан зогсооход чиглэсэн бодит ажлуудыг хийж ажиллах шаардлагатай.

Аймаг, нийслэлийн БОУ өмнөх оноос (7.9↑) оноогоор өсөж үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөлөл (9.9↑) оноогоор, ажлыг хянах механизм (4.2↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (8.1↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (9.4↑) оноогоор тус тус өсөж үнэлэгдсэн нь нөлөөлжээ. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ-ний хувьд 2025 онд 70.1 оноотой болж, өмнөх онтой харьцуулахад (7.9↑) оноогоор өсөж үнэлэгджээ. Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын БОУ хамгийн ихээр буюу (35.5↑) оноогоор, Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын БОУ (30.7↑) оноогоор тус тус өссөн. Харин Архангай аймгийн ЗДТГ-ын үнэлгээ хамгийн ихээр буурсан буюу (17.4↓) оноогоор буурч үнэлэгдсэн байна.

Аймаг, нийслэлийн үнэлгээг нэгтгэн дүгнэвэл, “алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх явдал”, алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал” гэсэн үзүүлэлтүүдийн үнэлгээ БОУ-нд чухал нөлөөг үзүүлжээ. Иймд БОУ доогуур түвшинд үнэлэгдсэн аймаг, нийслэлийн ЗДТГ-ын албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйг эрхэмлэн дээдлэх, төрийн үйлчилгээг хүнд сурталгүй хүргэхэд анхаарч ажиллах хэрэгтэй.

Дүүргүүдийн ЗДТГ-ын БОУ өмнөх оноос (7.0↑) оноогоор өсөж үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөлөл (11.1↑) оноогоор, ажлыг хянах механизм (3.0↑) оноогоор, авлигын бодит тохиолдол (6.3↑) оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (7.6↑) оноогоор тус тус өсөж үнэлэгдсэн нь нөлөөлжээ.

Дүүргүүдийн үнэлгээг нэгтгэн дүгнэвэл, иргэдтэй шууд харьцдаг байгууллагын хувьд “алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх явдал” хамгийн чухал үзүүлэлт бөгөөд ийм нөхцөл илэрсэн тохиолдолд үнэлгээнд хүчтэй, сөрөг нөлөөг үзүүлдэг нь хамаарлын шинжилгээгээр батлагдлаа. “Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл”, “дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл”-ийг дээшлүүлж ажиллахыг зөвлөж байна.

БОУ-ээр хамгийн өндөр оноотой байгууллагууд:

- Баянгол дүүргийн ЗДТГ
- Оюуны өмчийн газар
- Төрийн худалдан авах ажиллагааны газар
- Төв аймгийн ЗДТГ
- Дорноговь аймгийн ЗДТГ
- Стандарт, хэмжил зүйн газар.

Эдгээрээс Баянгол дүүргийн ЗДТГ хамгийн өндөр буюу 88.8 оноотой үнэлэгдэж тэргүүлсэн.

БОУ-ээр хамгийн бага оноотой байгууллагууд:

- Шүүх шинжилгээний ерөнхий газар
- Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ
- Архангай аймгийн ЗДТГ
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
- Боловсрол, шинжлэх ухааны яам.

Эдгээрээс Боловсрол, шинжлэх ухааны яам хамгийн бага буюу 44.2 оноотой үнэлэгдэж сүүлд эрэмбэлэгдсэн байна. Хамгийн бага оноотой үнэлэгдсэн 5 байгууллагын БОҮ-ний дундаж нь улсын дундаж БОҮ-ээс (8.1↓) оноогоор доогуур үнэлэгджээ. БОҮ доогуур үнэлэгдсэн байгууллагуудын үнэлгээг нэгтгэн дүгнэвэл, “удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл”, “дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл” эдгээр 5 байгууллагад бүгдэд нь муу үнэлгээтэй байгааг анхаарах шаардлагатай. Удирдлагууд нь өөрсдөөсөө эхэлж авлигын эсрэг идэвх, санаачилгатай манлайлж ажиллаж хэрэгтэй. Мөн “алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх явдал” байсаар байгааг таслан зогсооход чиглэсэн ажлыг хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

БОҮ хамгийн бага оноотой байгууллагуудад авлигаас урьдчилан сэргийлэх, бууруулахын тулд авлига, ашиг сонирхлын талаарх хуулийн мэдээллээр хангах, төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах, цалин хөлс, хангамж, орлогыг нэмэгдүүлэх, улс төрөөс бизнесийн бүлэглэлийг ангид байлгах, хяналтыг сайжруулах (байгууллагын дотоод хяналт, хараат бус хяналт, аудиторын үйл ажиллагааг сайжруулах) ажлуудыг зохион байгуулахыг санал болгож байна.

Монгол улсад авлига хамгийн их тархсан 5 институцээр “Шүүхийн байгууллага”, “Газрын алба”, “Улс төрийн нам”, “Төрийн захиргааны яам, агентлаг”, “Гаалийн байгууллага” байна. Уг үзүүлэлтийг 2024 онтой харьцуулбал, “Эрүүл мэндийн байгууллага”-ын үзүүлэлт өмнөх оноос гурван байраар сайжирч авлига хамгийн их тархсан 5 институцэд багтаагүй ч эхний 6 байгууллагад байна. Өнгөрсөн жил 7 дугаарт эрэмбэлэгдэж байсан “Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг” нь 2025 онд эхний 4 дүгээрт эрэмбэлэгджээ.

Өмнөх дөрвөн жилийн дундаж үнэлгээгээр, ирээдүйн 2 жилд Монгол Улсын авлигын нөхцөл байдал өөрчлөгдөхгүй хэмээн судалгаанд оролцогчдын 36.1 хувь нь хариулж байсан бол 2025 онд 38.0 хувь болж өссөн. Судалгаанд оролцогчдын 18.8 хувь “их өснө”, “өснө” хэмээн хариулсан нь өмнө жилүүдийн үнэлгээнээс 0.3 пунктээр л буурсан байв.

Авлигын шалтгаан, нөхцөлүүд цалин хөлс бага хэмээн 16.8 хувь, ажилгүйдэл, ядуурал, амьжиргааны түвшин, үнийн өсөлт 11.7 хувь, хувь хүний хандлага, шунал, ёс зүй 7.7 хувь, хүнд суртал их 7.1 хувь, эрх мэдлээ урвуулан ашиглах, эрх мэдэл төвлөрөл 5.0 хувиар эрэмбэлэгдсэн тул цаашид авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд эдгээр шалтгаан, нөхцөлийг харгалзан үзэхийг санал болгож байна.

Ашигласан материалын жагсаалт

- МУ-ын Ёс зүйн хороо. (2025). *Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, тогтоомжийн хэрэгжилт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн дүн, төлөв байдлын дүн*. Улаанбаатар: МУ-ын Ёс зүйн хороо. <https://cdn.greensoft.mn/uploads/users/5896/filesD.pdf>-ээс Гаргасан
- Transparency International. (2025). *Corruption Perceptions Index*. Transparency International. <https://www.transparency.org/en/cpi/2024>-ээс Гаргасан
- Архангай аймаг дахь төрийн аудитын газар. (2025). *Архангай аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлан*,. Архангай аймаг: Архангай аймаг дахь төрийн аудитын газар. file:///C:/Users/Dell/Downloads Гаргасан
- АТГ. (2025). *АТГ-ын 2025 оны эхний хагас жилд хийсэн ажлын тайлан*. Улаанбаатар: АТГ. https://iaac.mn/files/editor/source/Report_iaac_202506.pdf-ээс Гаргасан
- Б.Адьяатөр. (2025). *120 сургуульд 1.2 тэрбум төгрөг юунд зарцуулагдав?* <https://tug.mn/p/show/61888>-ээс Гаргасан
- Байгаль орчин, у. а. (2025). *Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны өргөдөл, гомдлын тайлан /2025 оны 1-р улирлын байдлаар/*. Улаанбаатар: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам. <https://mecc.gov.mn/storage/media/6beb26ba-7ad7-4d97-a902-eeeea9d4c540b.pdf>-ээс Гаргасан
- БШУЯ. (2025). *БШУЯ-ны 2025 оны 1 дүгээр сарын үйл ажиллагааны тайлан мэдээ*. Улаанбаатар: БШУЯ. <https://moe.gov.mn/post/164891>-ээс Гаргасан
- Л.Түвшинбат. (2025). *Авлигын төсөөллийн индексийн зарим үзүүлэлт өссөн*. <https://ubn.mn/p/78416>-ээс Гаргасан
- Нийслэлийн ЗДТГ. (2020). *Сонгинохайрхан дүүргийн тогтвортой хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичиг*. Улаанбаатар: НҮБ. https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/mn/6_Songinokhairkhan_document_draft_Dec-2020.pdf-ээс Гаргасан
- О.Алтангэрэл. (2024). *ХЗДХЯ*. mojha.gov.mn-ээс Гаргасан
- Транспэрэнси Интернэшнл Монгол. (2025). <https://news.mn>. <https://news.mn/r/2782728/>-ээс Гаргасан
- УИХ-ын гишүүн Н.Батсүмбэрэл. (2025). Нэр бүхий УИХ-ын гишүүд Ерөнхий сайдад П.Наранбаяр сайдыг огцруулах шаардлага хүргүүллээ: <https://news.mn/r/2809507/>-ээс Гаргасан
- Шүүх шинжилгээний ерөнхий газар. (2025). *Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө*. Улаанбаатар: Шүүх шинжилгээний ерөнхий газар. <https://nfa.gov.mn/uploads/files02025.pdf>-ээс Гаргасан

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Түүврийн хэмжээ, байгууллагын төрлөөр

№	Байгууллага	Шинжээчдийн тоо
	Яамд	400
1	Байгаль орчин аялал жуулчлалын яам	25
2	Барилга хот байгуулалтын яам	25
3	Батлан хамгаалах яам	25
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	25
5	Гадаад харилцааны яам	25
6	Зам, тээвэр хөгжлийн яам	25
7	Сангийн яам	25
8	Соёлын яам	25
9	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	25
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	25
11	Хууль зүй, дотоод хэргийн яам	25
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	25
13	Эрүүл мэндийн яам	25
14	Эрчим хүчний яам	25
15	Эдийн засаг хөгжлийн яам	25
16	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	25
	Агентлаг	680
17	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	20
18	Онцгой байдлын ерөнхий газар	20
19	Монополын эсрэг газар	20
20	Стандарт, хэмжил зүйн газар	20
21	Цаг уур, орчны шинжилгээний газар	20
22	Гаалийн ерөнхий газар	20
23	Татварын ерөнхий газар	20
24	Цагдаагийн ерөнхий газар	20
25	Улсын бүртгэлийн ерөнхий газар	20
26	Архивын ерөнхий газар	20
27	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	20
28	Гадаадын иргэн харьяатын газар	20
29	Нийгмийн даатгалын ерөнхий газар	20
30	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	20
31	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	20
32	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	20
33	Биеийн тамир, спортын улсын хороо	20
34	Соёл урлагийн газар	20
35	Иргэний нисэхийн ерөнхий газар	20
36	Ашигт малтмал, газрын тосны газар	20
37	Мал эмнэлгийн ерөнхий газар	20
38	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	20
39	Оюуны өмчийн газар	20
40	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	20
41	Төрийн худалдан авах ажиллагааны газар	20
42	Усны газар	20
43	Үндэсний геологийн алба	20
44	Жижиг, дунд үйлдвэрийн газар	20
45	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	20
46	Боловсролын ерөнхий газар	20
47	Ойн газар	20
48	Шүүх шинжилгээний ерөнхий газар	20
49	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	20
50	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	20
	Аймгийн засаг даргын тамгын газар	450
51	Архангай аймгийн ЗДТГ	15
52	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	15
53	Баянхонгор аймгийн ЗДТГ	15
54	Булган аймгийн ЗДТГ	15
55	Говь-Алтай аймгийн ЗДТГ	15
56	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	15

57	Дархан-Уул аймгийн ЗДТГ	15
58	Дорноговь аймгийн ЗДТГ	15
59	Дорнод аймгийн ЗДТГ	15
60	Дундговь аймгийн ЗДТГ	15
61	Завхан аймгийн ЗДТГ	15
62	Орхон аймгийн ЗДТГ	15
63	Өвөрхангай аймгийн ЗДТГ	15
64	Өмнөговь аймгийн ЗДТГ	15
65	Сүхбаатар аймгийн ЗДТГ	15
66	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	15
67	Төв аймгийн ЗДТГ	15
68	Увс аймгийн ЗДТГ	15
69	Ховд аймгийн ЗДТГ	15
70	Хөвсгөл аймгийн ЗДТГ	15
71	Хэнтий аймгийн ЗДТГ	15
72	Нийслэлийн ЗДТГ	20
73	Багануур дүүргийн ЗДТГ	5
74	Багахангай дүүргийн ЗДТГ	5
75	Баянгол дүүргийн ЗДТГ	15
76	Баянзүрх дүүргийн ЗДТГ	15
77	Налайх дүүргийн ЗДТГ	15
78	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	15
79	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	15
80	Хан-Уул дүүргийн ЗДТГ	15
81	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	15
	Нийт	1530

2.1. Яамдын БОҮ

№	Байгууллагын нэр	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	БОҮ
1	Эдийн засаг хөгжлийн яам	93.6	64.9	100	62.1	80.2
2	Сангийн яам	89.3	60.5	97.7	71.8	79.8
3	Батлан хамгаалах яам	87.4	60.6	100	70.2	79.5
4	Соёлын яам	89.5	50.2	100	71.3	77.7
5	Барилга хот байгуулалтын яам	85.4	54.8	100	65.6	76.4
6	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	84.6	50	100	71.1	76.4
7	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	83.8	42.7	100	64.8	72.8
8	Эрчим хүчний яам	79.5	52.5	97.1	59.6	72.2
9	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	72.7	51.6	96.9	62.8	71
10	Гадаад харилцааны яам	71.8	43.1	94.7	73.8	70.8
11	Эрүүл мэндийн яам	64.8	53.5	97.4	54.5	67.5
12	Зам, тээвэр хөгжлийн яам	65.3	44.8	100	54.7	66.2
13	Хууль зүй, дотоод хэргийн яам	58.9	41.9	100	62.4	65.8
14	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	57.1	37.8	97.6	67.8	65.1
15	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	46.8	36.8	65.4	36	46.3
16	Боловсрол, шинжлэх ухааны яам	47	30	61.9	38.1	44.2
Яамдын БОҮ		73.6	48.5	94.3	61.7	69.5

2.2. Агентлагуудын БОҮ

№	Байгууллагын нэр	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	БОҮ
1	Оюуны өмчийн газар	97.2	76.1	100	79.6	88.2
2	Төрийн худалдан авах ажиллагааны газар	85	74	100	84.4	85.8
3	Стандарт, хэмжил зүйн газар	93	66.4	100	72.6	83
4	Боловсролын ерөнхий газар	92.9	63.8	100	74.3	82.7
5	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	90.5	67.3	100	71.7	82.4
6	Ойн газар	93.2	60	95	79	81.8
7	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	85	63.3	100	76.3	81.1
8	Улсын бүртгэлийн ерөнхий газар	88.9	56	100	77.1	80.5
9	Соёл урлагийн газар	78.2	59.4	96.4	86.1	80
10	Архивын ерөнхий газар	90.7	61.7	93.9	72.9	79.8
11	Онцгой байдлын ерөнхий газар	86.9	68.8	100	63.4	79.8
12	Үндэсний геологийн алба	87.9	62.5	94.7	73.6	79.7
13	Иргэний нисэхийн ерөнхий газар	85.4	60.5	93.8	71.1	77.7
14	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	84.3	51.5	100	72.8	77.1
15	Татварын ерөнхий газар	79.9	55.1	97.1	71.6	75.9

16	Усны газар	76.5	56.7	100	68.8	75.5
17	Цагдаагийн ерөнхий газар	84.9	56.3	90.8	68.2	75.1
18	Гаалийн ерөнхий газар	84.7	58.3	87.6	61.7	73.1
19	Монополын эсрэг газар	84.2	46.4	100	61.1	72.9
20	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	78.2	55.3	88.2	65.3	71.7
21	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	71.4	47.1	100	68.1	71.6
22	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	71.3	55	82.4	73.5	70.5
23	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	76.4	52.8	89.4	61	69.9
24	Цаг уур, орчны шинжилгээний газар	80.9	48.8	97.4	51.8	69.7
25	Ашигт малтмал, газрын тосны газар	70.5	49.3	90.9	63.7	68.6
26	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	73.6	46.4	100	53.1	68.3
27	Нийгмийн даатгалын ерөнхий газар	72.1	48.4	87.5	64.7	68.2
28	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	81.9	44.9	94.3	51.5	68.2
29	Гадаадын иргэн харьяатын газар	76.4	39.7	86.6	67.1	67.5
30	Жижиг, дунд үйлдвэрийн газар	53.5	51.7	100	52.5	64.4
31	Мал эмнэлгийн ерөнхий газар	74.6	42.2	96.7	37	62.6
32	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	69.9	45.4	93.3	39.8	62.1
33	Биеийн тамир, спортын улсын хороо	55.2	45.5	94.1	53.1	62
34	Шүүх шинжилгээний ерөнхий газар	54.2	39.2	64.9	56.4	53.7
Агентлагуудын БОУ		79.7	55.2	94.6	66	73.9

2.3. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ

№	Байгууллагын нэр	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	БОУ
1	Төв аймгийн ЗДТГ	90.3	68.3	100	76.8	83.8
2	Дорноговь аймгийн ЗДТГ	93.2	64.1	100	74.9	83
3	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	92.4	63	100	76	82.8
4	Хөвсгөл аймгийн ЗДТГ	89.2	70.2	100	70.7	82.5
5	Сүхбаатар аймгийн ЗДТГ	83.1	61.2	96.4	73.9	78.7
6	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	88.1	50.4	100	64.8	75.8
7	Говь-Алтай аймгийн ЗДТГ	81.7	44.5	100	75	75.3
8	Нийслэлийн ЗДТГ	79.9	50.1	100	64.8	73.7
9	Завхан аймгийн ЗДТГ	81.3	46.9	100	64.3	73.1
10	Өвөрхангай аймгийн ЗДТГ	78	46.4	96.2	66.1	71.7
11	Увс аймгийн ЗДТГ	71.3	46.9	100	65.3	70.9
12	Дундговь аймгийн ЗДТГ	69.6	61.8	85.7	60.6	69.4
13	Орхон аймгийн ЗДТГ	66.9	51.9	89.2	65.8	68.4
14	Булган аймгийн ЗДТГ	71.1	42.4	91.6	66.3	67.9
15	Хэнтий аймгийн ЗДТГ	69.2	43.6	88.5	64.9	66.5
16	Өмнөговь аймгийн ЗДТГ	64.5	38.3	94.4	65.8	65.8
17	Баянхонгор аймгийн ЗДТГ	65.3	43.6	72.4	73	63.6
18	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	62.9	42.6	84.5	63.1	63.3
19	Дархан-Уул аймгийн ЗДТГ	61.2	41.7	95.5	48.3	61.7
20	Ховд аймгийн ЗДТГ	65.9	38	73.1	51	57
21	Дорнод аймгийн ЗДТГ	49.5	31.5	87.3	54.2	55.6

22	Архангай аймгийн ЗДТГ	53.7	31.6	68.5	51.3	51.2
Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ		74	49	92	65.3	70.1

2.4.Дүүргүүдийн ЗДТГ-ын БОУ

№	Байгууллагын нэр	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	БОУ
1	Баянгол дүүргийн ЗДТГ	86	84.7	100	84.4	88.8
2	Налайх дүүргийн ЗДТГ	84.7	59.7	100	75.1	79.9
3	Хан-Уул дүүргийн ЗДТГ	74.9	59.3	100	70.8	76.3
4	Багануур дүүргийн ЗДТГ	85.8	40	100	75	75.2
5	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	82.4	54	100	63.2	74.9
6	Баянзүрх дүүргийн ЗДТГ	75.6	48.1	92.9	68.4	71.2
7	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	65.6	50.6	92.9	64.4	68.4
8	Багахангай дүүргийн ЗДТГ	69.2	36.7	100	54.4	65.1
9	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	58.2	46.1	68.8	41.7	53.7
Дүүргүүдийн ЗДТГ-ын БОУ		75.8	53.2	94.9	66.4	72.6

Хавсралт 3. БОУ-ний дэд үзүүлэлтүүд, өмнөх оноос өөрчлөгдсөн оноо

3.1. Яамд

	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A12	A13	A14	A15	A16
Байгаль орчин аялал жуулчлалын яам	-31.6	-34.7	-27.0	-31.5	-15.6	-35.1	-32.9	-12.5	-27.3	-9.8	-17.9	-22.0	-21.7	-23.5	-36.9	-23.5
Барилга хот байгуулалтын яам	-19.1	-18.4	-9.8	-15.0	-10.5	-8.9	-2.3	-13.9	-7.5	42.0	38.5	-13.3	0.0	0.0	-14.2	-5.7
Батлан хамгаалах яам	-1.1	7.0	-0.3	-6.6	-0.3	0.0	7.1	-42.4	4.7	-14.2	-0.3	-12.5	0.0	0.0	-10.5	-6.5
Боловсрол, шинжлэх ухааны яам	9.7	7.5	19.5	8.1	14.9	14.9	8.0	15.9	6.1	-15.8	-6.2	9.7	-33.3	-27.5	0.8	5.4
Гадаад харилцааны яам	-18.8	-13.6	-9.9	-7.6	-31.4	-6.3	-26.2	40.0	-20.5	-14.9	-14.1	-10.0	0.0	-10.5	-1.1	-2.4
Зам, тээвэр хөгжлийн яам	7.4	22.9	7.1	7.2	8.8	3.3	25.0	-8.2	-8.9	1.9	13.5	0.0	0.0	0.0	-8.3	-6.4
Сангийн яам	14.7	22.5	10.2	20.5	21.7	17.0	21.0	1.6	14.4	16.3	15.7	8.2	4.3	1.0	0.9	3.9
Соёлын яам	8.7	4.6	5.5	4.0	8.0	9.1	6.4	11.6	5.8	-20.8	-17.7	-5.8	0.0	0.0	1.0	-3.7
Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	42.5	33.2	32.3	37.0	34.6	39.4	27.1	-1.5	5.1	0.3	-1.8	22.9	47.6	49.3	18.9	18.8
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	1.0	4.9	6.4	12.3	25.2	11.6	5.6	60.4	26.1	-12.9	4.6	-22.1	0.0	0.0	2.9	-2.6
Хууль зүй, дотоод хэргийн яам	-36.0	-28.2	-16.2	-33.3	-30.4	-35.8	-34.5	12.0	-44.5	-34.7	-54.8	-28.4	0.0	0.0	-30.0	-18.4
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	24.5	18.4	15.1	14.4	8.2	9.7	18.7	34.4	27.5	14.9	3.9	23.0	4.5	5.3	21.1	22.4
Цахим хөгжил, харилцаа холбооны яам	-16.2	-29.2	-24.6	-6.9	-47.9	-51.4	-20.5	22.3	-23.2	-15.7	5.7	1.7	0.0	-4.8	4.7	3.5
Эдийн засаг хөгжлийн яам	22.0	37.8	47.5	30.8	49.7	43.2	41.4	43.1	50.0	28.4	8.4	22.7	15.8	27.8	11.8	6.3
Эрүүл мэндийн яам	-6.2	-4.0	-8.6	-15.7	-8.3	-11.9	1.7	8.3	-6.0	4.8	15.8	5.8	-5.3	0.0	-4.6	1.4
Эрчим хүчний яам	24.6	28.9	24.3	22.8	52.3	30.4	22.6	-25.3	29.6	3.6	-11.7	20.3	15.8	16.3	6.3	11.6

3.2. Агентлаг

	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A12	A13	A14	A15	A16
Архивын ерөнхий газар	18.7	18.5	16.1	18.6	18.8	25.0	21.8	38.6	15.6	7.1	18.3	12.7	-5.6	0.0	13.5	13.5
Ашигт малтмал, газрын тосны газар	28.8	29.1	39.1	27.8	21.5	47.4	18.9	-25.7	16.9	-5.7	-4.2	20.3	35.3	35.2	21.5	11.8
Биеийн тамир, спортын улсын хороо	-21.0	-27.6	-22.5	-25.0	-39.2	-18.1	-13.0	-11.7	-6.5	-9.2	2.5	-7.5	-5.9	0.0	-11.6	-7.4
Боловсролын ерөнхий газар	28.3	22.9	29.6	27.9	37.4	33.4	34.0	17.9	37.6	23.6	17.5	16.9	0.0	0.0	15.4	25.2

Гаалийн ерөнхий газар	63.9	42.9	45.0	45.6	35.0	42.1	27.8	-7.1	43.8	13.3	5.9	28.8	9.0	8.2	7.0	8.1
Гадаадын иргэн харьяатын газар	7.5	1.3	-6.3	-3.0	-7.4	-3.5	-5.8	13.6	-5.4	-44.2	-18.3	11.1	-14.3	-12.5	-5.1	6.4
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	-3.3	24.5	10.8	1.6	7.1	9.8	25.2	-9.4	-0.1	19.5	18.2	-7.7	0.0	-13.3	-21.7	4.5
Жижиг, дунд үйлдвэрийн газар	-38.8	-36.0	-40.8	-36.7	-34.3	-39.1	-39.6	-46.9	-38.8	19.8	20.4	-30.9	0.0	0.0	-22.5	-31.4
Иргэний нисэхийн ерөнхий газар	36.1	21.9	33.8	33.0	27.0	26.9	24.0	16.7	23.8	19.2	20.0	24.4	5.8	-7.1	26.0	28.1
Мал эмнэлгийн ерөнхий газар	-10.9	2.6	3.0	-11.4	-6.7	1.2	8.3	7.5	-23.0	-10.9	-2.9	-5.4	0.0	-6.7	-26.8	-25.6
Нийгмийн даатгалын ерөнхий газар	9.6	4.2	6.8	16.5	10.1	5.6	4.5	0.0	0.0	-0.6	-7.4	8.3	-11.8	-13.3	11.4	14.1
Ойн газар	18.8	5.8	22.1	24.5	21.1	4.2	8.3	47.7	2.2	-12.9	3.1	11.2	0.9	9.3	21.2	17.8
Онцгой байдлын ерөнхий газар	15.2	18.8	14.4	7.8	2.0	5.4	17.8	-14.1	3.4	11.1	29.2	4.7	0.0	0.0	-1.4	2.0
Оюуны өмчийн газар	15.6	13.9	15.0	10.9	10.3	18.8	10.3	14.5	16.1	1.2	19.8	7.5	0.0	5.6	3.9	2.6
Соёл урлагийн газар	-25.2	-2.7	0.2	-24.4	3.2	-19.4	-3.2	30.4	-4.2	0.4	-3.3	4.4	-0.9	0.0	16.3	19.2
Стандарт, хэмжил зүйн газар	12.6	2.6	19.2	23.6	17.9	20.3	4.3	42.5	6.7	0.7	11.6	0.0	0.0	0.0	6.0	1.5
Татварын ерөнхий газар	-2.7	13.2	14.3	7.1	10.2	7.7	16.7	13.9	7.3	-3.3	11.1	4.3	0.0	-5.9	10.6	14.9
Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	14.6	13.1	6.5	25.4	12.8	19.6	20.6	-40.5	7.9	34.4	5.4	2.3	0.0	6.3	2.5	6.7
Төрийн худалдан авах ажиллагааны газар	16.4	19.1	19.4	22.6	17.8	20.1	24.8	-17.1	30.6	16.7	24.5	33.7	22.2	16.7	23.3	28.8
Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	-7.3	-0.6	0.0	-1.2	13.0	6.3	0.7	-1.9	10.2	-20.8	-16.7	2.0	-4.1	-5.2	-5.1	-15.1
Улсын бүртгэлийн ерөнхий газар	19.2	-6.7	28.3	18.3	0.9	15.1	10.5	10.4	1.6	-13.2	-10.4	6.7	0.0	0.0	18.1	17.3
Усны газар	-8.3	-3.7	-5.2	-3.9	-3.3	-3.8	-0.6	-5.4	-3.7	-22.6	-3.3	2.2	0.0	0.0	11.1	13.9
Үндэсний геологийн алба	62.1	45.1	47.6	44.1	43.1	52.7	36.0	12.6	35.9	1.9	10.8	31.0	35.9	48.1	31.9	23.3
Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	-14.4	-15.0	0.3	-11.5	-4.0	-9.9	-7.8	0.8	-11.3	6.9	7.2	-1.0	6.3	0.0	2.6	17.9
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	13.2	4.2	-1.8	11.7	19.4	1.5	11.9	5.8	7.9	-15.7	-19.0	-3.8	-5.6	-5.9	-7.6	2.3
Хөрөнгө оруулалт, худалдааны газар	3.9	20.9	-2.4	1.0	9.8	-4.2	-8.9	15.0	16.1	5.0	21.8	10.4	-4.4	-4.2	7.2	3.3
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	1.0	9.4	-12.7	-11.3	1.7	-15.0	-4.8	-10.4	-14.9	13.9	4.7	-18.3	0.0	0.0	-11.4	-17.2
Цаг уур, орчны шинжилгээний газар	36.4	-1.0	29.7	16.7	35.3	22.1	22.0	15.6	-1.2	12.5	-7.5	-2.4	14.7	20.0	-2.6	-6.0
Цагдаагийн ерөнхий газар	21.9	-3.6	4.2	15.4	9.9	8.0	7.5	22.9	-2.4	8.3	-11.1	10.2	-11.8	-1.1	9.6	2.7
Монополын эсрэг газар	33.2	2.2	12.5	14.7	0.8	3.3	-0.8	2.9	6.7	-16.1	-17.9	20.2	11.8	12.5	-5.6	-5.6
Шүүх шинжилгээний ерөнхий газар	-10.8	-37.8	-21.8	-7.2	-44.5	-30.3	-33.9	-31.4	-34.1	-29.5	-8.8	-19.9	-33.3	-31.0	-20.3	-17.0

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	-2.3	-0.9	-2.7	-0.8	0.7	12.9	-3.1	13.5	4.7	-22.2	-21.7	8.8	0.0	5.0	-7.6	-6.9
Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	6.7	-7.3	10.1	18.9	7.5	7.5	-2.9	40.4	22.2	-20.6	-2.9	10.4	-17.6	-17.6	15.0	14.6
Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	7.6	-8.6	10.0	-3.0	13.8	-2.4	-6.3	51.8	29.0	-17.1	-25.5	-4.0	12.5	13.3	13.9	8.2

3.3. Аймаг, нийслэлийн ЗДТГ

	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A12	A13	A14	A15	A16
Архангай аймгийн ЗДТГ	-13.3	-3.3	-13.3	-10.3	-1.1	-14.2	-11.6	5.0	-12.5	-36.3	-16.7	-19.6	-26.7	-36.4	-17.5	6.4
Баян-Өлгий аймгийн ЗДТГ	-25.3	-8.3	-22.1	-20.0	-3.7	-7.4	-8.8	-32.7	1.9	7.8	13.2	-17.3	-14.3	-16.7	7.7	16.7
Баянхонгор аймгийн ЗДТГ	31.7	25.0	20.8	32.1	17.9	33.9	36.3	23.1	29.4	14.0	-0.2	0.3	-3.6	16.2	35.6	36.8
Булган аймгийн ЗДТГ	-10.9	-10.8	-3.8	-3.7	-6.3	4.8	12.5	-7.3	6.7	-2.8	-14.2	-17.3	7.7	7.6	1.4	-9.6
Говь-Алтай аймгийн ЗДТГ	27.5	25.7	45.3	34.6	40.0	28.3	45.8	-27.1	30.4	5.2	-11.5	46.8	36.4	0.0	33.6	16.4
Говьсүмбэр аймгийн ЗДТГ	19.6	48.1	34.1	40.7	44.9	50.3	28.7	47.5	38.5	15.2	7.9	28.9	50.0	75.0	17.3	28.9
Дархан-Уул аймгийн ЗДТГ	-19.6	13.4	2.6	-17.6	34.3	23.4	7.1	-2.3	6.7	10.4	-13.8	1.7	15.4	24.2	3.6	-10.5
Дорноговь аймгийн ЗДТГ	-4.6	0.0	6.2	16.3	-1.3	10.1	6.3	16.0	-0.2	21.8	5.6	-5.1	0.0	7.7	-8.3	0.0
Дорнод аймгийн ЗДТГ	24.1	15.0	28.1	-4.3	-6.7	-4.6	0.2	-12.9	-18.4	4.9	-19.6	12.9	-4.0	5.7	13.1	8.9
Дундговь аймгийн ЗДТГ	11.5	5.0	35.1	6.7	24.5	4.4	12.7	-5.0	7.9	20.1	23.5	-5.0	0.0	-7.6	10.0	11.1
Завхан аймгийн ЗДТГ	17.1	30.6	0.0	13.0	23.1	27.6	32.0	27.5	17.1	8.3	-16.8	9.6	40.0	27.3	6.0	9.7
Орхон аймгийн ЗДТГ	3.4	-2.1	-8.4	-7.6	-3.8	1.9	-11.9	-15.5	-0.2	5.9	-5.8	0.9	6.7	14.7	7.8	6.8
Өвөрхангай аймгийн ЗДТГ	16.9	-0.9	-3.8	-11.0	-6.3	-8.0	1.4	18.8	27.0	10.6	-25.0	0.7	0.0	-7.7	-1.1	3.3
Өмнөговь аймгийн ЗДТГ	28.8	2.9	6.7	1.0	0.4	6.0	-2.1	3.6	-1.8	-9.2	-13.4	-4.0	0.0	0.0	20.0	1.3
Сүхбаатар аймгийн ЗДТГ	37.2	40.8	32.1	33.3	30.5	41.9	37.3	14.6	32.4	8.5	38.8	10.4	34.5	46.2	23.8	35.5
Сэлэнгэ аймгийн ЗДТГ	15.0	24.6	26.3	30.4	26.5	25.0	25.0	18.3	28.3	19.5	5.4	10.6	15.4	15.4	16.1	20.3
Төв аймгийн ЗДТГ	-5.8	0.4	-6.7	-3.1	5.4	1.7	3.6	-42.8	0.0	20.8	1.6	-3.8	0.0	0.0	-1.8	-4.0
Увс аймгийн ЗДТГ	8.9	-3.6	7.0	9.5	-6.3	1.7	-3.1	19.3	8.7	7.9	16.2	16.4	0.0	0.0	15.3	13.0
Ховд аймгийн ЗДТГ	10.4	21.4	7.1	8.9	7.7	11.5	16.9	3.3	23.2	0.6	-6.3	-14.3	0.0	5.5	8.9	-4.7
Хөвсгөл аймгийн ЗДТГ	30.0	28.4	22.9	31.4	30.8	35.4	19.2	-2.7	22.1	28.4	64.9	14.5	6.7	0.0	3.3	-4.2
Хэнтий аймгийн ЗДТГ	19.2	13.1	9.5	16.2	18.3	18.6	7.1	8.6	15.0	-1.6	15.5	-3.8	20.9	-7.7	20.9	13.9
Нийслэлийн ЗДТГ	-2.5	-2.5	-8.1	-4.0	-0.3	-5.9	-11.3	-35.6	-9.7	-1.2	8.0	-2.3	0.0	0.0	8.5	-4.7

3.4. Дүүргүүдийн ЗДТГ

	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A12	A13	A14	A15	A16
Багануур дүүргийн ЗДТГ	14.6	5.0	-15.0	6.3	8.3	0.0	-5.0	37.5	0.0	-2.1	-16.7	1.3	0.0	0.0	15.0	15.0
Багахангай дүүргийн ЗДТГ	62.5	6.3	18.8	68.8	62.5	25.0	75.0	25.0	4.2	-41.7	-50.0	-15.0	0.0	0.0	2.5	-18.8
Баянгол дүүргийн ЗДТГ	34.7	40.1	13.8	20.2	38.5	35.1	43.0	-12.7	31.4	37.5	18.8	37.8	27.3	16.7	27.1	26.3
Баянзүрх дүүргийн ЗДТГ	-3.0	-5.2	12.5	-5.3	-9.1	5.1	0.0	-20.0	10.0	-9.6	-4.5	5.4	-7.1	-7.1	4.1	-1.9
Налайх дүүргийн ЗДТГ	6.3	5.1	8.9	1.3	-1.0	6.3	2.4	62.5	10.5	2.3	30.6	16.6	0.0	0.0	16.5	18.2
Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	35.7	12.7	6.3	17.9	11.1	10.4	0.7	17.0	-1.6	6.3	9.6	-5.7	-1.1	-2.8	-8.3	-8.3
Сүхбаатар дүүргийн ЗДТГ	14.0	-12.3	5.0	3.6	5.0	11.1	10.0	49.0	7.5	-8.2	10.8	2.1	6.7	6.7	11.4	10.0
Хан-Уул дүүргийн ЗДТГ	-22.9	-21.2	-9.6	-16.5	-11.5	-13.5	-10.3	11.3	-12.1	-4.2	4.0	5.9	6.7	0.0	-2.1	-0.2
Чингэлтэй дүүргийн ЗДТГ	-15.2	7.1	13.5	4.0	17.1	10.0	7.3	13.2	14.6	29.2	12.1	9.5	30.4	37.3	9.3	21.6

Хавсралт 4. БОУ ба дэд шалгуур үзүүлэлтүүдийн хамаарал

4.1. Яамд

	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A12	A13	A14	A15	A16	БОУ
A1	1.00																
A2	0.94	1.00															
A3	0.89	0.93	1.00														
A4	0.95	0.92	0.90	1.00													
A5	0.83	0.89	0.90	0.82	1.00												
A6	0.88	0.93	0.95	0.88	0.93	1.00											
A7	0.91	0.96	0.90	0.88	0.87	0.88	1.00										
A8	0.03	0.01	0.15	0.19	-0.02	0.07	-0.02	1.00									
A9	0.79	0.82	0.84	0.82	0.86	0.84	0.85	0.22	1.00								
A10	0.36	0.41	0.39	0.38	0.41	0.42	0.56	-0.07	0.51	1.00							
A11	0.29	0.29	0.18	0.32	0.20	0.24	0.49	-0.05	0.40	0.79	1.00						
A12	0.85	0.76	0.75	0.79	0.60	0.66	0.76	0.05	0.65	0.48	0.33	1.00					
A13	0.58	0.55	0.50	0.60	0.43	0.51	0.48	-0.03	0.33	0.28	0.09	0.46	1.00				
A14	0.67	0.65	0.65	0.66	0.57	0.61	0.62	-0.01	0.46	0.36	0.13	0.55	0.96	1.00			
A15	0.84	0.72	0.71	0.86	0.52	0.66	0.70	0.39	0.71	0.31	0.35	0.81	0.54	0.57	1.00		
A16	0.84	0.69	0.68	0.80	0.52	0.63	0.68	0.22	0.65	0.38	0.34	0.89	0.53	0.56	0.95	1.00	
БОУ	0.36	0.44	0.34	0.40	0.29	0.40	0.46	0.05	0.47	0.41	0.31	0.21	0.62	0.59	0.44	0.34	1

4.2. Агентлагууд

	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A12	A13	A14	A15	A16	БҮҮ
A1	1.00																
A2	0.73	1.00															
A3	0.86	0.78	1.00														
A4	0.92	0.73	0.88	1.00													
A5	0.78	0.81	0.85	0.80	1.00												
A6	0.85	0.82	0.92	0.89	0.84	1.00											
A7	0.74	0.85	0.86	0.78	0.84	0.88	1.00										
A8	0.21	0.12	0.34	0.23	0.42	0.20	0.19	1.00									
A9	0.73	0.74	0.77	0.76	0.80	0.79	0.71	0.37	1.00								
A10	0.21	0.40	0.25	0.24	0.36	0.28	0.44	-0.26	0.21	1.00							
A11	0.06	0.39	0.17	0.15	0.14	0.17	0.30	-0.18	0.16	0.70	1.00						
A12	0.74	0.72	0.77	0.77	0.68	0.77	0.68	0.28	0.81	0.08	0.13	1.00					
A13	0.49	0.56	0.61	0.39	0.56	0.60	0.53	-0.05	0.48	0.32	0.17	0.49	1.00				
A14	0.54	0.48	0.56	0.41	0.53	0.59	0.46	0.02	0.46	0.23	0.06	0.47	0.92	1.00			
A15	0.54	0.48	0.68	0.64	0.64	0.59	0.51	0.44	0.70	0.13	0.16	0.74	0.44	0.47	1.00		
A16	0.45	0.50	0.64	0.59	0.58	0.53	0.60	0.38	0.67	0.17	0.23	0.72	0.31	0.25	0.87	1.00	
БҮҮ	0.38	0.44	0.51	0.47	0.57	0.50	0.50	0.42	0.59	0.27	0.27	0.56	0.36	0.42	0.67	0.59	1.00

4.3. Аймаг, нийслэлийн ЗДТГ

	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A12	A13	A14	A15	A16	БҮҮ
A1	1.00																
A2	0.83	1.00															
A3	0.78	0.81	1.00														
A4	0.88	0.80	0.82	1.00													
A5	0.69	0.81	0.83	0.74	1.00												
A6	0.76	0.88	0.80	0.81	0.91	1.00											
A7	0.80	0.83	0.81	0.82	0.83	0.86	1.00										
A8	0.55	0.61	0.61	0.52	0.62	0.63	0.50	1.00									
A9	0.65	0.74	0.71	0.67	0.82	0.88	0.77	0.72	1.00								
A10	0.40	0.52	0.41	0.38	0.53	0.57	0.50	0.09	0.45	1.00							
A11	0.48	0.39	0.42	0.47	0.31	0.38	0.30	0.17	0.28	0.44	1.00						
A12	0.58	0.77	0.64	0.71	0.60	0.63	0.61	0.51	0.52	0.53	0.49	1.00					
A13	0.44	0.69	0.50	0.57	0.65	0.69	0.62	0.40	0.65	0.26	0.10	0.58	1.00				
A14	0.39	0.66	0.43	0.50	0.53	0.68	0.45	0.38	0.60	0.23	0.03	0.43	0.75	1.00			

A15	0.76	0.80	0.80	0.75	0.79	0.80	0.79	0.56	0.80	0.51	0.47	0.68	0.53	0.41	1.00		
A16	0.75	0.76	0.70	0.73	0.71	0.71	0.60	0.59	0.66	0.34	0.41	0.65	0.54	0.61	0.83	1.00	
БOY	0.78	0.93	0.81	0.84	0.86	0.92	0.82	0.62	0.84	0.53	0.44	0.79	0.79	0.75	0.86	0.86	1.00

4.4. Дүүргүүдийн ЗДТГ

	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A12	A13	A14	A15	A16	БOY
A1	1.00																
A2	0.85	1.00															
A3	0.39	0.70	1.00														
A4	0.80	0.92	0.72	1.00													
A5	0.73	0.64	0.37	0.79	1.00												
A6	0.62	0.70	0.67	0.86	0.91	1.00											
A7	0.56	0.83	0.84	0.80	0.65	0.82	1.00										
A8	0.27	0.03	-0.61	0.00	0.25	-0.02	-0.28	1.00									
A9	0.80	0.96	0.72	0.94	0.74	0.84	0.88	0.06	1.00								
A10	0.60	0.72	0.49	0.52	0.18	0.17	0.53	-0.30	0.54	1.00							
A11	0.46	0.61	0.45	0.42	0.08	0.08	0.49	-0.36	0.41	0.95	1.00						
A12	0.38	0.63	0.86	0.61	0.37	0.58	0.85	-0.67	0.61	0.65	0.69	1.00					
A13	0.41	0.59	0.53	0.64	0.79	0.88	0.84	0.03	0.74	0.10	0.03	0.52	1.00				
A14	0.46	0.60	0.51	0.67	0.83	0.90	0.84	0.06	0.75	0.11	0.06	0.52	0.99	1.00			
A15	0.62	0.78	0.76	0.87	0.76	0.89	0.86	-0.23	0.87	0.46	0.33	0.74	0.79	0.77	1.00		
A16	0.62	0.88	0.59	0.85	0.60	0.66	0.78	0.02	0.87	0.66	0.55	0.58	0.64	0.63	0.81	1.00	
БOY	0.73	0.92	0.74	0.90	0.74	0.82	0.94	-0.14	0.93	0.67	0.59	0.79	0.77	0.78	0.91	0.91	1.00